

**УЛААНБААТАР ТЕАТРЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**



**УЛААНБААТАР ХОТ
2021**

УЛААНБААТАР ТЕАРТЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 20

2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын Засгийн газрын тогтоол болон НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засгийн зорилтод тухайн жилд тусган дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас дараах ажлуудыг зохион байгуулан ажиллав.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

1.1 “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” хөтөлбөрт Улаанбаатар театрт заасан заалт байхгүй болно.

1.2 Төрөөс баримтлах бодлогод заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн

Үндэсний соёл урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг өргөжүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах зорилтын хүрээнд;

Улаанбаатар театрын бүжиг анги байгуулагдсаны 10 жилийн ой энэ жил тохиож байгаа бөгөөд бүжиг ангийн хамт олон өөрсдийн гэсэн донж төрхийг агуулсан, үндэсний бүжгийн эх язгуурыг нь алдагдуулахгүйгээр тайзны орчин үеийн бүжигтэй хослуулсан, бүжигчний ур чадвар, эрч хүч, бүжиг дэглээчийн оюун ухаан, онгод хийморь, хөгжмийн зохиолчийн уран сэтгэмж мэдрэмж, хөг аялгуу, хэмнэлтэй хорших бүжгийн “RED” тоглолтыг ХҮН театрын тайзнаа амилуулж үзэгч олны хүртээл болгосон төдийгүй “10 жил” нэртэй цахим контентыг Star телевизээр бичүүлж, UniLive88, DDISH 900, Look TV-гээр төлбөртөй нэвтрүүлхээс гадна 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Стар телевизээр үзэгч түмэнд хүргэхэд бэлэн болоод байна.

Улаанбаатар театрын дуучин МУСТА Д.Шижирмаа нь мартагдаж буй өв уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн өвлөх, хөгжүүлэх, ард иргэдэд таниулах зорилгоор нумт хуур хөгжмийг сурч, шинэ уран бүтээлийг орчин үеийн хөгжимтэй хослуулан үзэгч түмэнд нумт хуурын ая эгшгийг түгээн дэлгэрүүлээд байна.

Хөгжмийн 13 бүтээл бүхий “Хөгжмийн домог” төслийн хөгжмийг үндэсний хөгжимд тааруулан хөрвүүлэх ажлыг хөгжмийн зохиолч О.Чинбат дуусгаж нот, партитурыг бэлэн болгож хөгжимчдөд хүлээлгэн өгсөн бөгөөд хөгжимчид хөл хорионы үеэр хувийн бэлтгэлийг хангаж, одоо найрал хөгжмийн нийллэгийн бэлтгэлүүд хийгдэж, аудио болон видео бичлэг хийх ажлууд үргэлжилж байна.

1.3 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл.

2.6.2.1. “Цахим соёл” арга хэмжээ

Олон нийтийн сэтгэл зүйг дэмжих, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар театрын хөгжимчид гэр гэрээсээ мэндчилж, “Иргэн та хувийн ариун цэвэр, нийгэмд хүлээсэн үүргээ чандлан мөрдөж аюулт вирусээс хайртай бүхнээ хамгаалаарай”, “Бусдадаа гэрэл түгээе”, “Бид хамтдаа сэргийлж чадна” зэрэг уриалгыг С1 телевиз, “Өлзий” телевиз, YUOTUBE сувгаар;

1. Yanni “World dance”
2. Coldplay хамтлаг “Viva la vida”
3. Taro Hakese “JonetsuTaireku” дуунуудаар онлайн контент хийж сошиал сүлжээгээр үзэгчдэд хүргэлээ.



Онлайн тоглолтууд

1. 2021.01.01. Онлайн: УБЧ А.Бат-Эрдэнэ “Чонон шогшоо” А.Мөнгөн хүүтэйгээ 2/
2. 2021.01.10. ТВ 8 Бит Бокс Рэй 1/48000
3. 2021.01.14. Онлайн: УБЧ ӨМАД “Мандах нар” 2/4300
4. 2021.01.18. Гацуурт компанийн үйлдвэр: УБЧ “Цагаан сарын бичлэг” Mongol HD TV 9 хүн
5. 2021.01.19. Гацуурт компанийн үйлдвэр: УБЧ “Цагаан сарын бичлэг” Mongol HD TV 9 хүн
6. 2021.01.27. SBN ТВ “Цагаан сарын бичлэг” бүжигчид 3/600.000
7. 2021.01.28. Монгол HD ТВ “Өнөө өглөө” нэвтрүүлэг 3/1.700
8. 2021.02.02. МҮОНТВ “Цагаан сарын бичлэг” НЗДТГ 13 хүн
9. 2021.02.03. МҮОНТВ “Цагаан сарын бичлэг” НЗДТГ 13 хүн
10. 2021.02.04. УБЧ “Сар шинийн Улаанбаатар” онлайн тоглолтын бичлэг ТВ9 52 хүн
11. 2021.02.05.Онлайн: УБЧ “Horse man” МАД “Сэр сэр салхи” 2/94.000
12. 2021.02.10. Онлайн: УБЧ “Horse man” МАД “Дөрвөн цаг” клип 2/189.000
13. 2021.02.11. Онлайн: УБЧ Дархад АД “Самгалдай” 2/2100
14. 2021.02.13. SBN ТВ “Дуртай өдөр” нэвтрүүлэг Бит Бокс Рэй 1/12100
15. 2021.02.16. Онлайн: УБЧ “Horse man” МАД “Дөрвөн цаг” 2/12000
16. 2021.02.17. Монгол HD ТВ УБЧ Б.Мягмарцэрэн “Өнөө өглөө” нэвтрүүлэг 1/12.000
17. 2021.02.19. Онлайн: УБЧ Х.Бархүү охинтойгоо 2/550.000
18. 2021.02.21. Онлайн: УБЧ А.Бат-Эрдэнэ “Хулангийн өргөө” 2/
19. 2021.02.27. Онлайн: УБЧ Хорчин АД “Нуун заяа” 2/975
20. 2021.02.28. Онлайн: УБЧ “Horse man” МАД “Талын 5 толгой”, “2 сэтгэл” 2/545.000
21. 2021.03.07. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
22. 2021.03.10. УБЧ С1 ТВ “33” нэвтрүүлэг Бит Бокс Рэй 1/45000
23. 2021.03.13. Онлайн: УБЧ Б.Мягмарцэрэн охинтойгоо 2/200.000
24. 2021.03.14. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
25. 2021.03.21. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
26. 2021.03.28. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
27. 2021.04.01. Онлайн: УБЧ “Эрчист ирмүүн” бүжгийн клип 3/5.000
28. 2021.04.04. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
29. 2021.04.04. Онлайн: УБЧ МАУД “Хэрлэнгийн баръяа” 1/
30. 2021.04.11. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
31. 2021.04.18. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
32. 2021.05.02-05.07 Гэр гэрээсээ онлайн бичлэг “Жонезу Тайрэку” УБЧ25 хүн
33. 2021.05.13. Онлайн: УБЧ МАД “Мандах нар” 2/1500
34. 2021.05.16. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу 12/
35. 2021.05.21. SBN ТВ “Дуртай өдөр” нэвтрүүлэг Б.Норовбанзад 1/5700
36. 2021.05.24. Онлайн: УБЧ МАД “Бүсгүй хүний заяа” 2/645
37. 2021.05.27. МҮОНТВ: MNB Sport суваг УБЧ Гинессийн арга хэмжээ Д.Баярт 1/
38. 2021.06.05. Blue sky: НИТХ Ж.Баябаясгалан Азийн хөгжлийн банк 12/3
39. 2021.06.24. УБЧ: Этник номерын шалгаруулалт /онлайн/
40. 2021.06.30. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
41. 2021.07.01. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
42. 2021.07.02. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
43. 2021.07.03. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
44. 2021.07.04. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
45. 2021.07.05. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
46. 2021.07.06. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
47. 2021.07.07. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/

48. 2021.11.27 С1 телевиз, YoutubeSanjaa show channel-аар Хийлч Ч.Дэлгэрцэцэг Улаанбаатар чуулга 15 жилийн ойн дээрээ Театр болсон тухай энтертаймент нэвтрүүлэг,

49. 2021.12.06 Нийслэл дэлгэц ХХК-ийн том дэлгэцээр бүжиг дэглээч, бүжгийн багш Д.Баярт, гоцлол бүжигчин Б.Норовбанзад нарын “Red” бүжгийн тоглолтын мэдээлэл, сурталчилгаа

1.4. Улсын болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт:


Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил энэ жил байхгүй болно.

1.5. Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Нумт хуур хөгжим

Монголчуудын дээр үеэс уламжлагдаж ирсэн, мартагдах шахсан сонирхолтой хөгжмийн зэмсгийн нэг бол нумт хуур хөгжим билээ. Нумт хуурын үүсэл бол нум сум үүссэнээс үүдэлтэй гэж үздэг. Нумт хуурыг эртний баатрууд дохио зангааны хэлбэрээр ашиглаж байсан байдаг. Дайтаж байхдаа нум сумаараа дуу авиа гаргаж эх орноо санан үгүйлж, ялалт байгуулахыг бэлэгшээж сэтгэлээ тайтгаруулахын тулд авиа гаргаж эхэлсэн байдаг. Сүүлийн үед мэргэжлийн урлагийн байгууллагууд энэхүү хөгжмийн зэмсгийн хэлбэрийг нь өөрчилж, нумыг нь хатуу модоор хийгээд, утсыг нь төмрөөр хийж, хөгжмийн зэмсэг болгон ашиглаж байна.

Улаанбаатар театрын дуучин, МУСТА Д.Шижирмаа нь мартагдаж буй өв уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн өвлөх, хөгжүүлэх, ард иргэдэд таниулах зорилгоор нумт хуур хөгжмийг сурч, шинэ уран бүтээл туурвин, үзэгч түмэнд нумт хуурын ая эгшгийг түгээн сурталчилж байна.



Улаанбаатар театрын уран бүтээлч битбокс Б.Нарандэлгэр нь МЭХ-ны "Соёлын довтолгоо" үндэсний хэмжээний төсөл хэрэгжүүлж эхлээд 3 жил болж байгаа билээ. Энэхүү аян нь хүмүүсийн хандлага, ёс зүй, өв соёлоо хамгаалж үлдэх, түгээн дэлгэрүүлэх, үндэсний дархлааг бий болгох, архигүй эрүүл нийгмийг бий болгох, ирээдүй хойч үеэ зөв хүн болгон төлөвшүүлэх зэрэг олон олон сэдвүүдээр СОЁЛЫГ_ТҮГЭЭГЧ"-дээрээ дамжуулан иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох нь энэхүү төслийн зорилго юм. Нарандэлгэр нь Өв_соёлоо_түгээн_дэлгэрүүлэхэд иргэн хүнийхээ хувьд мөн уран бүтээлчийнхээ хувьд ирээдүй хойч үедээ, ээж, аавуудад үндэсний дархлааг бий болгоход энэхүү төсөлд нэгдэж МЭХ-той хамтран аймаг, сумдаар явж лекц, сургалт хийхээс гадна тухайн аймгуудад байгаа асрамжийн төвийн үйл ажиллагаануудтай танилцаж тэдэндээ бас багахан ч болтугай урам зориг өгөхийг хичээж ажилладаг билээ. Тухайн ажил нь Covid-19 цар тахлын улмаас түр завсарлаад байгаа бөгөөд 3-р улирлаас үргэлжлүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Мөн одоогоор Монголд анх удаа beatbox, хөөмий beat, хуур beat сургалтыг онлайнаар эхлүүлэн амжилттай ажиллаж үндэсний өв соёлыг ард түмэнд түгээн дэлгэрүүлж байна.

2021 оны 12 дугаар сарын 14-нд СОЁЛЫН ЭЛЧ нарын 3-р чуулга уулзалт болсон. Уг чуулга уулзалтанд гадаад харилцааны хувьд гадаад сурталчилгааны үйл ажиллагааг цогц, нэгдмэл тогтолцоонд оруулах санаачилга гаргаж Соёлын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран "Гурван яамны хамтын ажиллагааны төлөвлөгөө"-г баталж, хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд [СОЁЛЫН ЭЛЧ](#) нарын үйл ажиллагааг төрийн бодлоготой уялдуулах, олон нийтэд сурталчлах, эрх зүйн орчныг нь хууль тогтоомжийн хүрээнд сайжруулах, дипломат харилцааны шугамаар дэмжлэг үзүүлэх, гадаад сурталчилгаа болон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад оролцоог нь нэмэгдүүлэх, нэгдмэл, цогц тогтолцоог бүрдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.



“Бий Биелгээ” нь олон ястны түүх, уламжлал, заншил, дуу хөгжим, үлгэр домог, туульс, хувцас өмсгөл, тоглоом наадам зэргийг өргөн утгаар нь өөртөө цогцлоон багтааж уламжлагддаг ба үндэстэн, ястнуудын амьдрал, өвөрмөц ахуй байдал, ёс заншил, уламжлал, сэтгэлгээний онцлогийг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх бүжгийн урлаг юм. Биелгээг гэрт, тойрон суусан хүмүүсийн дунд, зай багатай газар бүжиглэдэг байснаас цээж гарын хөдөлгөөн нарийн хөгжсөн бөгөөд монгол хүний ажил үйлс, зан үйл, хэв шинж, амьдралын агуулгыг биелээч хүний сэтгэлийн хөдлөл, уран намбаар биелж харуулдаг гайхалтай урлаг билээ. Энэхүү өв соёлыг ард түмэнд түгээн дэлгэрүүлж сурталчлах зорилгоор бүжиг дэглээч, бүжгийн багш Д.Энхгэрэл болон театрын бүжигчид “Монгол ТВ”-ийн өглөө хөтөлбөрт орж ард түмэнд цэнхэр дэлгэцээрээ дамжуулан бие биелгээ заалаа.



1.6. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт;

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд соёл, урлагийн чиглэлээр нийт 4 ажил төлөвлөгдсөн бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 92%-ийн гүйцэтгэлтэй байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр **1.1.1, 1.2.1, 2.6.4.1, 2.6.6.1**, дахь заалт буюу 4 ажил тусгагдсанаас 2021 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар театр дэлхий дахинд үүссэн шинэ коронавирусийн нөхцөл байдалтай холбогдуулан 92%-ийн хэрэгжилттэй ажилласан байна.

1.1.1 Урлагийн төрөл зүйлийг хөгжүүлэх замаар, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан таниулах ажлын эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлсэн байна.

Монголын уламжлалт хөгжмийн зэмсгүүдийг таниулан сурталчлах, үндэсний хөгжмийг орчин үеийн цахилгаан хөгжимтэй хослуулсан шинэлэг хэлбэрийн онлайн тоглолт зохион байгуулах;

Хэрэгжилт: Улаанбаатар театрын бүжиг анги байгуулагдсаны 10 жилийн ой энэ жил тохиож байгаа бөгөөд бүжиг ангийн хамт олон өөрсдийн гэсэн донж төрхийг агуулсан, үндэсний бүжгийн эх язгуурыг нь алдагдуулахгүйгээр тайзны орчин үеийн бүжигтэй хослуулсан, бүжигчний ур чадвар, эрч хүч, бүжиг дэглээчийн оюун ухаан, онгод хийморь, хөгжмийн зохиолчийн уран сэтгэмж мэдрэмж, хөг аялгуу, хэмнэлтэй хорших бүжгийн “RED” тоглолтыг ХҮН театрын тайзнаа амилуулж үзэгч олны хүртээл болгосон төдийгүй “10 жил” нэртэй цахим контентыг Star телевизээр бичүүлж, UniLive88, DDISH 900, Look TV-гээр төлбөртэй нэвтрүүлхээс гадна 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Стар телевизээр үзэгч түмэнд хүргэхэд бэлэн болоод байна.

Улаанбаатар театрын дуучин МУСТА Д.Шижирмаа нь мартагдаж буй өв уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн өвлөх, хөгжүүлэх, ард иргэдэд таниулах зорилгоор нумт хуур хөгжмийг сурч, шинэ уран бүтээлийг орчин үеийн хөгжимтэй хослуулан үзэгч түмэнд нумт хуурын ая эгшигийг түгээн сурталчилж байна.

Хөгжмийн 13 бүтээл бүхий “Хөгжмийн домог” төслийн хөгжмийг үндэсний хөгжимд хөрвүүлэх ажлыг хөгжмийн зохиолч О.Чинбат дуусгаж нот, партитурыг бэлэн болгож хөгжимчдэд хүлээлгэн өгсөн бөгөөд хөгжимчид хөл хорионы үеэр хувийн бэлтгэлийг хангаж, одоо найрал хөгжмийн нийллэгийн бэлтгэл дуусаж, аудио болон видео бичлэгийн ажлууд хийгдэж байна.

1.2.1 “Соёл, урлагийн сар” нөлөөллийн үйл ажиллагаа:

Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа урлаг соёлын томоохон үйл ажиллагаануудад буй урлагийн тоглолтуудад мэргэжлийн урлагийн байгууллагуудыг манлайлан оролцоно.

Хэрэгжилт “Инноваци ба тогтвортой хөгжлийн зорилгууд” үзэсгэлэн, Аялал жуулчлалын холбооны олон улсын “Аялал жуулчлалын өдөр” нээлт, Нийслэлийн 382 жилийн ойн хүндэтгэлийн ёслол Мэлхийт хөшөө, Аялал жуулчлалын форум, ИТМ-2021 үзэсгэлэн яармаг зэрэг соёлын томоохон үйл ажиллагаанд урлагийн тоглолт үзүүлж ажилласан.

2.6.4.3 Иргэд жуулчдад зориулсан нийтийг хамарсан урлагийн тоглолт, үйл ажиллагаа зохион байгуулна.

Ардын урлагийг иргэд болон гадаадын жуулчдад сурталчлах онлайн контентыг нэвтрүүлэх;

Хэрэгжилт: Дэлхийн хэмжээнд цар тахал дэгдэж, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулахад хүндрэл үүссэн энэ нөхцөлд манай театрын хамт олон жуулчдад зориулсан тоглолтыг онлайн хэлбэрээр Театрын урын санд байгаа шилдэг бүтээлүүдийг онлайн хэлбэрт оруулах, мартагдсан олон ястны дуу, хөгжим, бүжгийн төрлийн бүтээлүүдийг сэргээн туурвих зэрэг ажлуудыг шат дараатайгаар зохион байгуулан ажиллаж байна. 2021 оны төлөвлөгдсөн уран бүтээлүүдээс гоцлол хөгжимчин Бархүү, Б.Мягмарцэрэн нар “Хоёр сэтгэл”, “Талын таван толгой”, “Сэр сэр салхи” гэх 3 ардын дууг, хөгжимчин А.Мөнгөн, Н.Энхмаа нар “Бүсгүй хүний заяа”, “Мандах нар”, “Хэрлэнгийн барьяа”, “Нуун заяа” зэрэг ардын дуунуудыг сэргээн тоглосон.

2.6.6.1 “Улаанбаатар” театрын үйл ажиллагааг өргөжүүлж театрын статустай болгоно.

Улаанбаатар хөгжмийн модерн театрын төслийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Нийслэлийн Засаг даргад танилцуулж үйл ажиллагааг шат дараатайгаар зохион байгуулах;

Хэрэгжилт: Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан Улаанбаатар чуулгыг театрын статустай болгох төслийг III улиралд Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдээд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр “Улаанбаатар театр” ОНӨТҮГ болгох 148 дугаар тогтоол батлагдсан.

Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх “ХОТЫН СОЁЛ” аянд Улаанбаатар театр нэгдэж байгууллагын соёл болон иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, сурталчлах аянд идэвхтэй хамрагдаж чадлаа.

Үүний тулд хувь хүн бүр өөрөөсөө эхэлж, үр хүүхдүүдээ зөв үлгэр дуурайлал үзүүлэхээс гадна бусдын төлөө сэтгэж, нийгэмдээ юу хийж чадах вэ гэдгийг бодох нь зөв. Мөн олон нийтийн дунд биеэ зөв авч явж, бусдад саад учруулах үйлдэл хийхгүй байх, ил задгай шүлс, хогоо хаяхгүй, бусдадаа үлгэрлэж, байгаль дэлхийгээ хүндэлж харьцах нь эргээд бидний ирээдүйн нийгэм түүний хэрээр сайхан байх үндэс бүрдэнэ гэдийг нийт иргэдэд түгээн дэлгэрүүлэх үүднээс цахим сүлжээгээр дамжуулан соёлыг түгээлээ.



Улаанбаатар театр нь “Хотын соёл” аяны Эрүүл амьдралын зөв дадал хэвшил, зөв хооллолт, ажлын байрны дасгал хөдөлгөөний хүрээнд албан хаагч, уран бүтээлчид 7 хоногт 2 удаа ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшлээд байна. Хөдөлгөөний дутагдал, гэмтсэн уушгийг нөхөн сэргээх, стресс бухимдлын эсрэг зөв дадал хэвшлийг бий болгосон.



Олон нийтийн сүлжээгээр “Хотыг соёл”-ыг түгээх





Шагайт дасгал



Албан хаагч нар иогоор хичээллэж байгаа нь.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: “ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

2.1 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны хагас жилийн байдлаар

a/ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 100 дугаар тушаалын 7-р хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын хүрээнд Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон тайлан мэдээг цаг тухай бүр нь хэрэгжүүлж ажиллаж байна.

Хүснэгт 1

	Нийт	МУ-ын хууль	МУ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ын зөвлөмж, тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч
Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо							3		1		
Хяналт авсан нийт зүйл заалтын тоо							3		1		
Бүрэн хэрэгжсэн	100%						3		1		
Хэрэгжих шатанд	70%										

Хэрэгжилт хангалтгүй	30%											
Хэрэгжээгүй	0											
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй												
Биелэлтийн дундаж							100%		100%			100%

б/ Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт

1. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/85 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Ажлын хэсэг байгуулах тухай;

Хэрэгжилт: Нийслэл хотод Коронавируст (Ковид-19) халдварын тохиолдол хурдацтай нэмэгдэж хүн амын дунд тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу нийт албан хаагч нарыг “Нэг хаалга-Нэг шинжилгээ” PCR шинжилгээнд харьяа дүүргийнхээ заасан хэсэгт хамрагдахыг уриалж, цахимаар мэдээлэл өгч ажиллаа.

2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс эхэлсэн бүх нийтийн бэлэн байдлын үеэр хийх “Нэг хаалга-Нэг шинжилгээ” ажлын үеэр Сүхбаатар дүүргийн 7,8-р хороонд ажиллахаар хуваарилагдсан боловч Сүхбаатар дүүргийн шуурхай штаб өөрсдийн хүчээр ажиллах болсон гэх мэдээлэл өгснийг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболдод уламжилсан.

Ингэснээр манай байгууллагын албан хаагчдыг амьдарч байгаа гэрийн хаягаар дуудаж ажиллуулах хуваарьт оруулсан. Манай байгууллага 62 албан хаагчтай бөгөөд цагдаагаас гэрийн хаягаар дуудагдаж ажиллах 51 албан хаагчийн нэрсийг гэрийн хаяг, холбогдох утасны дугаарын хамт жагсаалт гарган НЗДТГ-ын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дүүрэг хороо хариуцсан мэргэжилтэн Ц.Нямдэлгэрийн ERP систем дэх хаягаар илгээсэн. Эдгээр 51 албан хаагчийн бэлэн байдлыг хангаж, өдөр бүр байгууллагын дотоод цахим сүлжээгээр мэдээлэл солилцож ажиллаж байна.

62 албан хаагчаас 0-3 насны хүүхэдтэй 7 эмэгтэй албан хаагч, 60-аас дээш насны 1 эмэгтэй албан хаагч, жирэмсэн 2 албан хаагч, ар гэрийн гачигдлын улмаас чөлөөтэй байгаа 1 албан хаагчийг хасаж 51 албан хаагчийн нэр өгсөн. 2 дугаар сарын 12-ны өдрөөс өнөөдрийг хүртэл цагдаагаас гэрийн хаягаар дуудагдаж ажилласан хүн байхгүй байгаа бөгөөд хөл хорионы энэ өдрүүдэд Нийслэлийн Онцгой комиссын хурлын бэлэн байдлыг хангаж тайз үйлдвэрлэлийн ангийн дарга Б.Түмэндэлгэр, дууны техникч Т.Цолмон нар өдөр бүр 10-18 цагийн хооронд ажилласан.

2. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/87 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай;

Хэрэгжилт: Халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг баримтлан ажил үүргээ гэрээсээ гүйцэтгэж дээд газраас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх, өдөр бүр ажлын явц, үр дүнг шууд удирдлагад тайлагнах, оршин суугаа

газраас өөр тийшээ явахгүй байх, гар утсаа нээлттэй байлгаж утасны дуудлага, сошиалд тухай бүр хариу өгөх зэргээр ажилласан.

Заалт: Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/108 дугаар захирамжийн хэрэгжилт;

Хэрэгжилт: Байгууллага доторх халдвар хамгаалал, цэвэрлэгээ үйлчилгээндээ хяналт тавьж ажилласан. Орж гарах хүмүүсийн халуун хэмжиж, QR бүртгэлийг киоск дэлгэцэнд , байршуулж, орж гарсан иргэдэд маскаа зүүж гараа ариутгахыг тогтмол шаардлага тавихыг үүдний хамгаалалтын албанд зөвлөмж болгов. Мөн төв хаалган дээр гар ариутгалын автомат төхөөрөмж байршуулав.

3. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн А/161 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Коронавируст халдвар /ковид -19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай;

Хэрэгжилт: Байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг алдагдуулахгүйгээр ажилтан, албан хаагчдыг 30 хүртлэх хувиар ажиллуулж, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг эхийг гэрээр ажиллах боломжийг хангаж Улаанбаатар театрын захиргааны албан хаагч нар хувиар гарган ээлжээр ажиллаж, уран бүтээлч нар дуудлагын горимд шилжин ажилласан.

4. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/221 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Коронавируст халдвар /ковид -19/-аас сэргийлэх, тархалтыг бууруулах зарим арга хэмжээний тухай;

Хэрэгжилт: Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг даргаас нутгийн захиргааны байгууллагуудад өгсөн үүрэг даалгаврын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. “Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-тай нийцүүлэн, хүний бөөгнөрөл үүсэхээс урьдчилан сэргийлж, албан хаагчдыг ажиллуулах нарийвчилсан хуваарь гаргаж, ирцийг бүртгэж байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг алдагдуулахгүйгээр ажилтан, албан хаагчдыг 30 хүртлэх хувиар ажиллуулж, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг эхийг цахимаар гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлж захиргааны ажиллах болмжтой 6 албан хаагч ээлжээр ажиллаж, Уран бүтээлч нар цахимаар гэрээсээ ажилласан.

5. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/246 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Коронавируст халдвар /ковид -19/-аас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай;

Хэрэгжилт: Албан хаагчдыг аль болох олноор ажлын байранд ирүүлэхгүй байхаар зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд ажлын байранд болон цахим хэлбэрээр зайнаас ажиллаж байгаа албан хаагчдын бэлэн байдлыг хангаж, байгууллагын дотоод цахим сүлжээгээр цаг үеийн байдалтай холбоотой мэдээ, мэдээлэл, судалгааг тухай бүр хүргэж

ажилласан. Албан хаагчдыг 30 хүртлэх хувиар ажиллуулж, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг эхийг цахимаар гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлж захиргааны ажиллах боломжтой 6 албан хаагч ээлжээр ажиллаж, Уран бүтээлч нар цахимаар гэрээсээ ажилласан.

6. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/246 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Коронавируст халдвар /ковид -19/-аас сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай;

Хэрэгжилт: Албан хаагчдыг аль болох олноор ажлын байранд ирүүлэхгүй байхаар зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд ажлын байранд болон цахим хэлбэрээр зайнаас ажиллаж байгаа албан хаагчдын бэлэн байдлыг хангаж, байгууллагын дотоод цахим сүлжээгээр цаг үеийн байдалтай холбоотой мэдээ, мэдээлэл, судалгааг тухай бүр хүргэж ажилласан. Албан хаагчдыг 30 хүртлэх хувиар ажиллуулж, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг эхийг цахимаар гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлж захиргааны ажиллах боломжтой 6 албан хаагч ээлжээр ажиллаж, Уран бүтээлч нар цахимаар гэрээсээ ажилласан.

7. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/265 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай;

Хэрэгжилт: Хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчдын 10 хүртэл хувийг ажлын газрын үнэмлэх, албан байгууллагын тодорхойлолтыг үндэслэн хувийн болон албаны тээврийн хэрэгслээр хуанлийн өдрөөр автомашины улсын дугаарын сүүлчийн орон тэгш, сондгой тоогоор төгссөнөөр тодорхой маршрутын дагуу хязгаартайгаар замын хөдөлгөөнд оролцуулж, түгжрэл үүсгэхгүй байх хариу арга хэмжээ авч ажилласан.

8. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/313 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай;

Хэрэгжилт: Төрийн захиргааны болон орон нутгийн өмчит үйлдвэрийн ажилтан, албан хаагчдыг ажлын байранд нь ажиллуулахгүй байх, хуулийн этгээдийн үйл ажиллагааг тусгай горимд, /уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах/ шилжүүлж, зайлшгүй шаардлагаар биечлэн ажиллах албан хаагчдын тоог бууруулах зохион байгуулалтын Одоогоор 61 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд коронавирусын халдвар авсан тусгаарлалтанд байгаа албан хаагч байхгүй, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тарилгын 1-р тунг 25 албан хаагч хийлгэсэн байна.

9. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/477 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай;

Хэрэгжилт: “Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшин тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг хэрэгжүүлж халдвар хамгааллын дэглэмийг сахиж, өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулахгүй байхад анхаарч, эрх бүхий байгууллага албан тушаалтны шаардлагыг биелүүлэхийг хүн, хуулийн этгээдэд үүрэг болгох үүднээс нийт албан хаагч нарт мэдээллийг цахимаар хүргэж ажилласан.

10. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/779 дугаар захирамжийн хэрэгжилт;

Заалт: Ажлын хэсэг байгуулах тухай;

Хэрэгжилт: Сайжруулсан түлшний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжруулах, борлуулалтын цэгийн түлшний нөөцийг бүрдүүлэх, цэгийн тоог нэмэгдүүлж жигдрүүлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, түлшний хэрэглээг жигд хүртээмжээр хангах, сайжруулсан түлшний нөөцлөлт, борлуулалт, түгээлтийн үйл ажиллагаанд өдөр тутамд хяналт тавьж ажиллуулах үүднээс чуулгын эрэгтэй албан хаагч нар Баянзүрх дүүргийн 24-р хорооны 14 хэсэгт хуваарилан ажилласан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”

3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт:

а/ Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. МУ-ын “Төрийн албаны тухай хууль, соёлын тухай”-ийн биелэлтийг хангаж ажиллах, хэрэгжилтийг бүтэн жилээр гаргаж тайлагнана.

Хэрэгжилт: Нийслэлийн харьяа мэргэжлийн урлагийн байгууллагын хувьд Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахын зэрэгцээ Монгол Улсын Төрийн албан тухай хууль, Соёлын тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан 62 хүний орон тоонд бариулан ажиллуулж байгаа 27 мэргэжлийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөл, Соёлын яамнаас гаргасан жишиг тодорхойлолтын дагуу шинэчлэн боловсруулсан. Тус албан тушаалын тодорхойлолтод нийцсэн чадварлаг мэргэжлийн хүмүүсээр нөөцөө бүрдүүлэн, албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс, нэмэгдэл олговор, шагнал урамшуулал, тусламж дэмжлэгийг зохих журмын дагуу олгож, албан хаагчийн сургалтын хөтөлбөр, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.

Хэрэгжилт: Нийслэлийн Аудитын газар, Нийслэлийн дотоод аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмж, батлагдсан төсвийн хүрээнд дэх орлого зарлагын гүйлгээ, 2021 оны жилийн төсөв, сар улирлын тайлан мэдээ болон холбогдох баримтуудыг мэдээллийн самбар болон өөрийн

байгууллагын цахим хуудас, шилэн дансанд байршуулж иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн.

б/ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн үйл ажиллагаа

1. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулах;

Хэрэгжилт: Нийслэл дэлгэц ХХК-ийн том дэлгэцээр бүжиг дэглээч, бүжгийн багш Д.Баярт, гоцлол бүжигчин Б.Норовбанзад нарын “Red” бүжгийн тоглолтын мэдээлэл, сурталчилгаа

- С1 телевиз, YoutubeSanjaa show channel-аар Хийлч Ч.Дэлгэрцэцэг Улаанбаатар чуулга 15 жилийн ойн дээрээ Театр болсон тухай энтертаймент нэвтрүүлэг,
- Late night of Miko шоуны шинэ жилийн тусгай хөтөлбөрт Хийлч МУСТА Ч.Дэлгэрцэцэг, Э.Дашням нар театрын тухай болон уран бүтээлийн дээжээсээ толилуулав.
- Юнилайв 88, ДДИШ 900, Look TV IPTV-үүдээр бүжиг ангийн 10 жилийн ойд зориулсан “10 жил” бүжгийн тоглолтыг шууд дамжуулав.
- UBS ТВ-ийн “Өглөөний хөтөлбөр”-ийн “Ажилсаг Улаанбаатар” буланд Улаанбаатар театрын уран бүтээлийн тухай 2 удаагийн нэвтрүүлэгт оролцов.
- Монгол HD тв-ийн өглөө хөтөлбөрт уран бүтээлчид
- МҮОНРТВ-ийн Соёлын цаг булан
- Amaraa’s weekly шоунд Дарга Р.Мөнхсайхан
- Үндэсний мэдээллийн Монцамэ агентлагийн сэтгүүлд онцлох уран бүтээлчдийн тухай мэдээлэл А4 нийтлэл,
- Монцамэ сэтгүүлд Улаанбаатар театрын дарга Р.Мөнхсайханы театрын үйл ажиллагаа, их хотын театрын тухай ярилцлага
- Стар ТВ-ээр “Хан хөхий уянга” Лимбэ хөгжимчин Б.Мягмарцэрэнгийн соло тоглолт
- Ёочин хөгжимчин Ч.Марал-одтой Улаанбаатар театрын поп оркестрын хамтарсан “Vivace” тоглолтын бичлэгийг нэвтрүүлсэн.
- Юнивиш, ДДИШ, Look TV-д “Мауглитай танилцсан нь” циркчилсэн үзүүлбэрийг контент болгон байршуулав.
- Бүжгийн “10 жил” бүжиг ангийн 10 жилийн ойд зориулсан тоглолтын бичлэгийн 12 дугаар сарын 31-ний өдөр Стар ТВ-ээр нэвтрүүлнэ.
- Coldplay хамтлаг “Viva la vida”, Yanni “World dance”, Taro Hakese “JonetsuTaireku” дуунуудаар Уонлайн контент хийж сошиал сүлжээгээр үзэгчдэд хүргэлээ.

2 . Соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Хэрэгжилт: НЗДТГ-НАЖГ, ГХЯ, БОАЖЯ-тай хамтарч ажилласаар ирсэн, соёл урлагийн үйл ажиллагаа гадаадад гарцгүй байгаа энэ цаг үед чуулгын уран бүтээлч хамт олон БНСУ, БНХАУ-ыг Хөх хотын алслагдмал мужийн театруудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх хэлэлцээрийн ажлууд хийгдэж байна.

3. Шинэлэг хэлбэрийн урсгал чиглэлээр хамтарсан уран бүтээл туурвих сэтгэлгээг дэмжин, дуучид, хөгжимчид, бүжигчдийн тайлан тоглолтыг зохион байгуулах;

Хэрэгжилт: Бүжгийн багш Д.Баярт, гоцлол бүжигчин Б.Норовбанзад нарын хамтарсан “RED” уран бүтээлийн тайлан тоглолт, Гоцлол хөгжимчин Б.Мягмарцэрэнгийн “Хан Хөхийн уянга” нэртэй бие даасан тоглолт, хөгжим ангийн уран бүтээлчдийн “Баярын үдэш” концертыг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж, байгууллагын зүгээс урын сангаа баяжуулсан, ур чадвараа нэмэгдүүлсэн, үзэгч олонд тайлангаа тавьсан, шинэлэг урсгал чиглэлийн бүтээл туурвисан албан хаагчдаа дэмжиж урамшуулсан.

4. *Чуулгын урын санг баяжуулах зорилгоор онлайн тоглолтыг найруулан тавина*

Хэрэгжилт: “Бүжиг ангийн 10 жилийн ойд зориулсан “10 жил” бүжгийн онлайн тоглолтыг UniLive88, DDISH 900, Look TV-ээр нэвтрүүлэв.

“Хан хөхийн уянга” Лимбэ хөгжимчин Б.Мягмарцэрэнгийн лимбэний гоцлолт тоглолт

Улаанбаатар театрын хөгжим анги, гоцлол хөгжимчин Ч.Марал-Одтой хамтарсан “Vivace” тоглолт

в/ Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг

1. *Албан хаагчдыг мэргэжлийн сургалтад хамруулна. /Цахим болон танхим/*

Хэрэгжилт: Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тайлант хугацаанд танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулсан 28 удаагийн сургалтаар нийт 212 албан хаагч хамрагдсан. Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх зорилгоор ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа 10 албан хаагчид ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж, байгууллагын зүгээс хувь хүний хөгжлийг дэмжиж, суралцах нөхцлөөр хангаж ажиллаж

2. *Одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг албан хаагчдад таниулан хэрэгжилтийг хангаж ажиллах;*

Хэрэгжилт: Монгол Улсын Төрийн албан тухай хууль, Соёлын тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж болон Улсын Онцгой комисс, Нийслэлийн Онцгой комисс, Нийслэлийн шуурхай штабаас ирүүлсэн чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, цаг алдалгүй албан хаагчдад хүргэх зорилгоор мэдээллийн бамбарт байршуулж, байгууллагын дотоод цахим сүлжээгээр таниулан сурталчлах ажлыг зохион байгуулж, ажилласан.

3. *Театрын хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, мансууруулах бодис хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалтыг орох;*

Хэрэгжилт: 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр театрын албан хаагч нарыг эрүүл мэндийн цогц сургалтанд хамруулсан. Сургалтыг зөвлөх их эмч орсон бөгөөд эрүүл зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маягт хэрхэн суралцах, биеийн дархлааг яаж унгалгүй эрч хүчтэй амьдрах, дасгал хөдөлгөөний ач тус, архи, тамхины зохисгүй хэрэглээ мөн албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, мансууруулах бодис хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалтуудыг тус тус орсон.

Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай хуулийг мөрдөж ажиллах;

Хэрэгжилт: Улаанбаатар чуулгын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан Улаанбаатар чуулгын ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрмийг www.ubchuulga.mn цахим хуудсанд байршуулсан, уран бүтээлийн анги тус бүрээр дүрэм журмын хавтас нээж албан хаагч нарт танилцуулсан. 2021 оны эхний хагас жилд ёс зүйн зөрчил гаргаж арга хэмжээ авагдсан албан хаагч байхгүй. Мөн ажлын байранд тамхи татах, архидан согтуурах болон

бусад хэлбэрийн донтолтын эсрэг видео шторк, ухуулга, сануулга бүхий зурагт хуудсыг зохих журмын дагуу байршуулан ажилласан.

4. *Аж ахуйн нээж, байгууллагын үйлдвэрлэлийн орчин нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан байна.*

Хэрэгжилт: Тайз техникийн ажилчдад өдөр бүр хөдөлмөр хамгаалал, аюулгүйн ажиллагааны журам, цахилгаан хэрэгсэлтэй ажиллах зааварчилгаа, өргөх буулгах механизмтай ажиллах зааварчилгаа, галын аюулгүй байдлын зааварчилгаа, багаж хэрэгсэлтэй ажиллах зааварчилгаа зэргийг тайз үйлдвэрлэлийн ангийн дарга Б.Түмэндэлгэр хариуцан тогтмол зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж, ажилд гаргаж хэвшсэн. Ковид-19 цар тахлын улмаас 2021оны 10 дугаар сар хүртэл Улаанбаатар чуулгын тайз, үзэгчдийн танхимд ажил зохион байгуулагдаагүй тул хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөн тохиолдол гараагүй. 11, 12 дугаар сард соёл урлагийн үйл ажиллагааг нээсэнтэй холбоотойгоор Нийслэлийн Соёл урлагийн газар, Сүхбаатар дүүрэгтэй гурвалсан Хариуцлагын гэрээ байгуулж, тус гэрээнд заасан халдвар хамгааллын дэглэм болон заал дүүргэлтийн 50 хувийг барьж, захиалгат ажлуудыг авч хариуцлагатай ажилласан. Мөн байгууллагын орчинд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт бүрэн хангагдсан.

Байгууллагын ажилтан, албан хаагч, нийт уран бүтээлчдэд зориулсан эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, уран бүтээлчдийг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна;

Хэрэгжилт: Цар тахлын улмаас хөл хорионд удаан хугацаагаар хоригдоод байгаа албан хаагчдынхаа эрүүл мэндийн нөхцөл байдалд дэм болох зорилгоор хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх цахим сургалтыг 2 удаа, хоол хүнсээр дамжуулан биеийн дархлаагаа дэмжих шилдэг аргуудын талаар зөвлөмжийг цахим хэлбэрээр 2 удаа зохион байгуулж ажилласан. Тус сургалтад давхардсан тоогоор нийт 141 албан хаагч хамрагдсан.

Театрын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх төрөлжсөн болон багц шинжилгээнд хамруулах ажлыг 2021 оны IY улиралд Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн захиргаатай байгуулсан 2 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээний хүрээнд зохион байгуулж, эрүүл мэндийн сөрөг шалтгаант оношлолтой албан хаагчийг нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөгөөр хангаж ажилласан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тайлан, мэдээ гаргах, архивт нөхөн бүрдүүлэлт хийж, хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн бүртгэх;

Хэрэгжилт: Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг edoc.ub.gov.mn вебээр хөтлөн, захиргааны албан хаагчдыг “НАГ”-аас зохион байгуулж буй сургалтанд хамруулж ирсэн явсан бичгийг цаг тухайд нь шийдвэрлэн ажиллаж байна. Тус чуулгын захиргааны албан хаагч нар 2021 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн цахим сургалтанд хамрагдаж архив, албан хэрэг мэдээ гаргах болон архивын эрхлэгч Б.Сувд-Эрдэнэ архивт нөхөн бүрдүүлэлт хийж, хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн бүртгэн ажиллаж байна.

5. *Хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллах;*

Хэрэгжилт: Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг www.edoc.ub.gov.mn онлайн албан хэрэг хөтлөлтийн

нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. Баримт бичигт шийдвэрлэх хугацааг заасан, дурдсан хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

6. Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллах;

Хэрэгжилт: Цар тахлын улмаас хөл хорионд удаан хугацаагаар хоригдоод байгаа албан хаагчдынхаа эрүүл мэндийн нөхцөл байдалд дэм болох зорилгоор хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх цахим сургалтыг 2 удаа, хоол хүнсээр дамжуулан биеийн дархлаагаа дэмжих шилдэг аргуудын талаар зөвлөмжийг цахим хэлбэрээр 2 удаа зохион байгуулж ажилласан. Тус 4 сургалтад давхардсан тоогоор нийт 92 албан хаагч хамрагдсан. Чуулгын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх төрөлжсөн болон багц шинжилгээнд хамруулах ажлыг 2021 оны IV улиралд Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн захиргаатай байгуулсан 2 жилийн хугацаатай хамтран ажиллах гэрээний хүрээнд зохион байгуулж, эрүүл мэндийн сөрөг шалтгаант оношлолтой албан хаагчийг нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөгөөр хангаж ажилласан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт театрын албан хаагчдын 93.6 хувийг хамруулсан.

Г/ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайруулах үйл ажиллагаа

1. Улаанбаатар чуулгын үзэгчдийн сэтгэл ханамжийн байдалд судалгаа хийж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.

Хэрэгжилт: Өмнөх удаагийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлтийн дагуу 2021 оны сүүлийн хагас жилийн үйл ажиллагаандаа олон нийтийн хэрэгслээр уран бүтээлүүдээ хүргэж сэтгэл ханамжийн судалгааг Google doc-оор авахад нийт 86 хүн хамрагдсан бөгөөд үзэгчдийн сэтгэл ханамж 13 хувиар өссөн үзүүлэлттэй байлаа.

2. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар: Байгууллагын төсөв, эд хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулж, ил тод байдлыг ханган ажиллана.

Хэрэгжилт: Урсгал зардлыг батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу зарцуулан үйл ажиллагаагаа явуулж, өр төлбөр үүсгэлгүй хэмнэж зарим зардлуудад хязгаар тогтоосон бөгөөд албан тасалгаануудын дотоод дулааныг хэвийн хэмжээнд барьж, их танхимын дулааныг зөвхөн хүлээн авалт үйл ажиллагаатай үеэр дулаан нэмэлтээр өгч ажиллаж байна.

3. Урлагийн захиалгат тоглолтууд, тайзны түрээс, чуулгын уран бүтээлчдийн концер, жүжиг, онлайн контентоос орлогыг бүрдүүлэх;

Хэрэгжилт: Театрын үйл ажиллагааны үндсэн чиглэл болох урлаг соёлын үйл ажиллагаанаас нийслэлийн төсөвт 2021 онд 20 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй бөгөөд цар тахлын улмаас соёл урлагийн үйл ажиллагааг хориглож байсан учир эхний хагас жилд орлого төвлөрүүлэх ажил зогсонги байсан. Соёл урлагийн үйл ажиллагаа нээсэнтэй холбогдуулан 11 сарын 15-ны өдрөөс эхлэн тайзны захиалгат ажлууд болон урлагийн захиалгат тоглолт, тайзны уран бүтээлээ үзэгч олон нийтэд хүргэж орлого олох боломж нээгдсэн. Мөн, одоо хийгдэж байгаа онлайн контентуудаас орлого төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллаж байна. 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийслэлийн төсөвт 16,350,000 төгрөг төвлөрүүлээд байна.

Манлайллын зорилтын хүрээнд

1. Үндсэн хөрөнгө болон байгууллагын сан хөмрөгт бүртгэгдсэн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг сайжруулах;

Хэрэгжилт: Өмч хамгаалах байнгын зөвлөлийг эхний улиралд хуралдаж, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг явуулж дууссан. Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг сайжруулах талаар албан хаагчдад зааварчилгаа өгч ажилласан.

2. Хувийн чадвараа хөгжүүлэх;

Хэрэгжилт: Санхүүгийн мэдлэг, бүх төрлийн даатгалын мэдлэг, төрийн албаны тухай хуулийн мэдлэгийг сайжруулах зорилгоор санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллаж сургалтыг цахимаар авч эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж ажилласан.

3. Мэргэжлийн өндөр ур чадвар бүхий баг бүрдүүлж ажиллах;

Хэрэгжилт: Чуулгын хөгжмийн бүрэлдэхүүнд зориулж ардын болон цахилгаан хөгжмөөр гадаадын том том бүтээлийг найруулж урын сангаа баяжуулах зорилгоор хөгжмийн зохиолч О.Чинбаттай хөдөлмөрийн гэрээ байгуулан хамтарч ажиллаж байна. Мөн Улаанбаатар чуулгыг өөрийн гэсэн удирдаачтай болгохын тулд их хуур хөгжимчин Б.Эрхэмбаярыг Монголын улсын консерваторид удирдаачаар сургаж байна.

Уран бүтээлчдийн тайлан тоглолтууд;

2021 оны 11 дүгээр сарын 22 -ны өдөр Улаанбаатар театрын гоцлол хөгжимчин, “Авьяаслаг Монголчууд-2015” шоуны дэд байрын шагналт МУСТА Б.Мягмарцэрэнгийн 2 дахь бие даасан “Хан хөхийн уянга” тоглолт Монгол улсын филармонийн тайзнаа тоглогдож, үзэгчдийн халуун алга ташилтан дор амжилттай зохион байгуулагдсан. Тоглолтонд Улаанбаатар театрын нийт уран бүтээлчид хамтран ажилласан.





Ёочин хөгжимчин МУСТА Ч.Марал-Одын бие даасан III дахь тоглолт 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр On'n #Off_Production-нд амжилттай тоглогдож үзэгч түмэнд хүрсэн.

Энэхүү тоглолтонд Монголын болон дэлхийн сонгодог хөгжмүүд эгшиглэхээс гадна Үндэсний поп оркестр, цахилгаан хөгжмийг хослуулан орчин үеийн хэм хэмнэлд тааруулан, шинэчлэн найруулсан уран бүтээлийн тоглолт болсон. Ерөнхий найруулагчаар "Улаанбаатар театр"-ын дарга Р.Мөнхсайхан ажилласан.



Улаанбаатар театрын 15 жил, бүжиг ангийн хамт олон Монголын бүжгийн урлагт өөрсдийн уран бүтээл, өнгө төрх, сэтгэл зүрхээрээ бүтээн туурвиж, ажиллаж хөдөлмөрсөний 10 жилийн ойн хүрээнд "RED" тоглолтыг 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдөр ХҮН театр зохион байгууллаа.

Үндэсний бүжгийн төрлүүдийг эх язгуур хэлбэрээс гадна тайзны бүжиг, орчин үеийн бүжигтэй хослуулан бүжгийг бүтээн туурвихдаа бүжигчний ур чадвар, эрч хүч, бүжиг дэглээчийн оюун ухаан, онгод хийморь, хөгжмийн зохиолчийн уран сэтгэмж мэдрэмж, хөг аялгуу, хэмнэлтэй хорших бүжгийн давтагдашгүй мэдрэмжийг ард түмэнд төрүүлсэн тоглолт боллоо.




Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан Улаанбаатар чуулгыг театрын статустай болгох төслийг III улиралд Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдээд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр “Улаанбаатар театр” ОНӨТҮГ болгох тухай 148 дугаар тогтоол батлагдсан. Улаанбаатар театр болсонтой холбогдуулан өвөл цагийн нээлтийн “COLORS OF MONGOLIA” тоглолтыг 2021 оны 12 дугаар сарын 10-ний өдөр өөрийн тайзнаа тоглож, 2006 оноос хойш тоглогдсон уран бүтээл болон үйл ажиллагааны зургийн үзэсгэлэнг гаргалаа.




Монголд Улсад циркийн урлаг үүсэж хөгжсөний 80 жилийн ойд зориулан Монгол Улсын Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас циркийн урлагийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ТББ, холбоод /Монголын циркчдийн холбоо, Монголын мэргэжлийн циркчдийн холбоо, Улаанбаатар театр, Улаанбаатар цирк/-тэй хамтран тусгайлсан хөтөлбөрийг зохион байгуулж ажиллаа.

Тус тоглолт 2021 оны 12 дугаар сарын 10-наас 2021 оны 12 дугаар сарын 15-ний өдрийг хүртэл Буянт-Ухаа спорт цогцолборт зохион байгуулагдлаа. Энэхүү арга хэмжээ нь Улаанбаатар циркийн болон бусад цирк, продакшн, студи –ээс уран бүтээлчид оролцохоос гадна, одоогийн байдлаар бусад урлагийн салбарууд хамтран оролцож төслийг амжилттай хэрэгжүүллээ. Хүүхэд залуучуудад циркийн урлагийг таниулан сурталчилах, хүүхэд залуучуудын сонирхолыг татаж улмаар циркийн залуу хойч үеийг бэлдэхэд нэн чухал бөгөөд хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа ард иргэдэд орчин үеийн техник технологийг ашиглаж өргөн зурвасын телевиз, интернет орчинг ашиглаж нэг доор олон үзэгчдэд хүргэх боломжтой юм.

Интернет орчинг ашиглаж видео контент түгээснээр Монгол циркийн урлагийн одоогийн түвшин, уламжилж ирсэн циркийн үзүүлбэр мөн Монголын ардын урлаг, сонгодог урлаг, орчин үеийн урлагийг нэг доор гадаадын үзэгчдэд сонирхуулж улмаар аялал жуулчлалыг дэмжсэн нэгэн томоохон контент болох боломжтой юм.





2021 оны 12 дугаар сарын 23-ний өдөр Улаанбаатар театрын хөгжим ангийн бие даасан “Баярын үдэш” тоглолт тоглогдохоор бэлтгэл ажилдаа ороод байна. Уг тоглолтонд Монголын болон дэлхийн сонгодог хөгжмүүд эгшиглэхээс гадна үндэсний хөгжмийг цахилгаан хөгжимтэй хослуулан орчин үеийн хэм хэмнэлд тааруулан шинэчлэн найруулсан уран бүтээлийн тоглолт болсон.



Улаанбаатар театрын 2021 онд оролцсон захиалгат тоглолтууд:

1. 2021.01.01. Онлайн: УБЧ А.Бат-Эрдэнэ “Чонон шогшоо” А.Мөнгөн хүүтэйгээ 2/
2. 2021.01.10. ТВ 8 Бит Бокс Рэй 1/48000
3. 2021.01.14. Онлайн: УБЧ ӨМАД “Мандах нар” 2/4300
4. 2021.01.18. Гацуурт компанийн үйлдвэр: УБЧ “Цагаан сарын бичлэг” Mongol HD TV 9 хүн
5. 2021.01.19. Гацуурт компанийн үйлдвэр: УБЧ “Цагаан сарын бичлэг” Mongol HD TV 9 хүн
6. 2021.01.27. SBN ТВ “Цагаан сарын бичлэг” бүжигчид 3/600.000
7. 2021.01.28. Монгол HD ТВ “Өнөө өглөө” нэвтрүүлэг 3/1.700
8. 2021.02.02. МҮОНТВ “Цагаан сарын бичлэг” НЗДТГ 13 хүн
9. 2021.02.03. МҮОНТВ “Цагаан сарын бичлэг” НЗДТГ 13 хүн
10. 2021.02.04. УБЧ “Сар шинийн Улаанбаатар” онлайн тоглолтын бичлэг ТВ9 52 хүн
11. 2021.02.05.Онлайн: УБЧ “Horse man” МАД “Сэр сэр салхи” 2/94.000
12. 2021.02.10. Онлайн: УБЧ “Horse man” МАД “Дөрвөн цаг” клип 2/189.000
13. 2021.02.11. Онлайн: УБЧ Дархад АД “Самгалдай” 2/2100
14. 2021.02.13. SBN ТВ “Дуртай өдөр” нэвтрүүлэг Бит Бокс Рэй 1/12100
15. 2021.02.16. Онлайн: УБЧ “Horse man” МАД “Дөрвөн цаг” 2/12000
16. 2021.02.17. Монгол HD ТВ УБЧ Б.Мягмарцэрэн “Өнөө өглөө” нэвтрүүлэг 1/12.000
17. 2021.02.19. Онлайн: УБЧ Х.Бархүү охинтойгоо 2/550.000
18. 2021.02.21. Онлайн: УБЧ А.Бат-Эрдэнэ “Хулангийн өргөө” 2/
19. 2021.02.27. Онлайн: УБЧ Хорчин АД “Нуун заяа” 2/975
20. 2021.02.28. Онлайн: УБЧ “Horse man” МАД “Талын 5 толгой”, “2 сэтгэл” 2/545.000
21. 2021.03.07. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
22. 2021.03.10. УБЧ С1 ТВ “33” нэвтрүүлэг Бит Бокс Рэй 1/45000
23. 2021.03.13. Онлайн: УБЧ Б.Мягмарцэрэн охинтойгоо 2/200.000
24. 2021.03.14. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
25. 2021.03.21. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
26. 2021.03.28. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
27. 2021.04.01. Онлайн: УБЧ “Эрчист ирмүүн” бүжгийн клип 3/5.000
28. 2021.04.04. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
29. 2021.04.04. Онлайн: УБЧ МАУД “Хэрлэнгийн баръяа” 1/
30. 2021.04.11. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
31. 2021.04.18. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу С.Эрдэнэцэцэг
32. 2021.05.02-05.07 Гэр гэрээсээ онлайн бичлэг “Жонезу Тайрэку” УБЧ25 хүн
33. 2021.05.13. Онлайн: УБЧ МАД “Мандах нар” 2/1500
34. 2021.05.16. Монгол HD ТВ “Ододтой бүжиглэе” шоу 12/
35. 2021.05.21. SBN ТВ “Дуртай өдөр” нэвтрүүлэг Б.Норовбанзад 1/5700
36. 2021.05.24. Онлайн: УБЧ МАД “Бүсгүй хүний заяа” 2/645
37. 2021.05.27. МҮОНТВ: MNB Sport суваг УБЧ Гинессийн арга хэмжээ Д.Баярт 1/
38. 2021.06.05. Blue sky: НИТХ Ж.Баябаясгалан Азийн хөгжлийн банк 12/3
39. 2021.06.24. УБЧ: Этник номерын шалгаруулалт /онлайн/
40. 2021.06.30. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
41. 2021.07.01. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
42. 2021.07.02. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
43. 2021.07.03. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
44. 2021.07.04. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
45. 2021.07.05. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
46. 2021.07.06. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
47. 2021.07.07. Хүй 7 худаг: Наадам 2021 бичлэг 11/
48. 2021.09.11. Сүхбаатарын талбай: НАЧА “Өвлиг өнтэй давъя” өдөрлөг 5/100

49. 2021.09.13. НЗД “Оюутнуудын хичээлийн жилийн нээлт-УБт тавтай морил” 1/ Live дамуулалт.
50. 2021.09.13. Blue sky: УИХ Б.Энх-Амгалан гишүүн 2/50
51. 2021.09.19. Өвөрхангай: НЗДТГ Ширээт цагаан нуур 14/60
52. 2021.09.23. Төв цэнгэлдэх: ХУД “Намрын ногоон өдрүүд” хаалт 1/300
53. 2021.09.24. Новотел: НАЖГ “Ногеса-2021” нээлт 5/60
54. 2021.09.27. УБЧ: НСУГ “Геодези ой” 46/160
55. 2021.09.27. Новотел: АЖХолбоо “О.У-н аялал жуулчлалын өдөр” нээлт 1/50
56. 2021.10.04. Сүхбаатарын талбай: Нийслэлийн нээлттэй хаалганы өдөр 1/200
57. 2021.10.08. Хүн театр: УБЧ 93-р сургууль. Багш нарын өдөр 34/30
58. 2021.10.08. Уран ган: НЗД-н орлогч Ж.Сандагсүрэн, УИХ-н гишүүн Н.Учрал JCI зүүсгэл2/
59. 2021.10.12. 1-р эмнэлэг: УБЧ 4/100 орчим
60. 2021.10.14. 1-р эмнэлэг: УБЧ 5/100 орчим
61. 2021.10.14. Герман ЭСЯ-ны хажууд: НҮГ зөвлөх тогоочийн номын нээлт 1/40
62. 2021.10.15. One event hall: УБЧ 15/80
63. 2021.10.17. Яармаг Сансар худалдааны төв: НЗДТГ Нийслэлийн ойн шторк зураг авалт 1
64. 2021.10.18. Иргэний танхим: НЭМГ хурлын нээлт 1/50
65. 2021.10.20. УБЧ: НЗДТГ ЭМ-н сургалт 29
66. 2021.10.23. Хангарди 14 давхарт: НЗДТГ мэтгэлцээний нээлт 4/40
67. 2021.10.26. МҮХАҮТ: НАЖГ “Аялал Жуулчлалын форум” нээлт 4/80
68. 2021.10.28. Хангарди 15 д: НИТХ аймгуудын ИХ-н дарга нарт 7/20
69. 2021.10.29. Мэлхийт хөшөө: НЗДТГ Нийслэлийн 382 жил 10/25
70. 2021.10.29. Хангарди 16д: НЗДТГ Нийслэлийн 382 жил, хотын үе үеийн дарга нар 11/30
71. 2021.10.29. НОСК шагнал гардуулалт 3/80
72. 2021.10.29. Үндэсний музей: НЗДТГ Үзэсгэлэнгийн нээлт 2/40
73. 2021.10.30. Боловсролын 100 жил бичлэг 1/
74. 2021.10.30. Мишээл экспо: НАЖГ “ИТМ-2021” үзэсгэлэн яармаг 13/90
75. 2021.10.31. Загастайн даваа: Ерөнхий сайд, ЗТЯ Замын нээлт 1/40
76. 2021.11.04. Тэрэлж: НЗДТГ СХД-н ИТХ-ын төлөөлөгчдөд 12/80
77. 2021.11.04. Номадс зүүн хаалга: НЗДТГ Хэрлэн дарга 1/40
78. 2021.11.05. МҮХАҮТ: НЗДТГ Гангамөрөн “Нийслэлийн ЖДҮҮ-н анхдугаар зөвлөгөөн-2021”
79. 2021.11.06. МҮХАҮТ: НЗДТГ Гангамөрөн Үзэсгэлэнгийн нээлт 6/60
80. 2021.11.06. One event hall: НЗДТГ Ганболд 3/120
81. 2021.11.08. МХО: УИХ, НЗДТГ Шилдэг...шагнал гардуулалт 32/200
82. 2021.11.12. Корпорэйт: УБЧ улсын 2-р эмнэлэг ой
83. 2021.11.12. Хангарди 15д: НЗДТГ Аймгуудын 3Д нарт 7/30
84. 2021.11.12. Их наяд 6д: УБЧ УДЭТ 90 жил ой 1/100
85. 2021.11.12. Тэрэлж: НЗДТГ Төмөртөмөө, Монголын боксын холбоо 14/
86. 2021.11.16. Их тэнгэр: Ерөнхий сайд, ЗГХЭГ 2/
87. 2021.11.22. Налайх: Шадар сайд “Ахмадын хөгжлийн төв”-н нээлт 1/
88. 2021.11.24. Блу скай 23д: Соёлын яам “Хандивлагчдын уулзалт” 13/70
89. 2021.11.25. МУИС Урлаг заал: УБТ 4/
90. 2021.11.25. Мишээл экспо: НСУГ “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн төв” нээлт 1/
91. 2021.11.25. Бодь ресторан: НИТХ төлөөлөгчдөд 1/
92. 2021.11.26. Футзаал: УБТ, МОНЦАМЭ 12/
93. 2021.11.29. УБТ: “Босоо цагаан гурвалжин” бүжгийн жүжиг 25/280
94. 2021.11.30. Үндэсний музей: НСУГ Үзэсгэлэн нээлт 2/
95. 2021.11.30. УБТ: “Босоо цагаан гурвалжин” бүжгийн жүжиг 25/300

96. 2021.12.01. УБТ: “Босоо цагаан гурвалжин” бүжгийн жүжиг 25/250
 97. 2021.12.03. On and Off: УБТ “Vivace” хандивын тоглолт 18/
 98. 2021.12.04. Хүн театр: УБТ-ын бүжигчин Д.Баярт, Б.Норовбанзад “Red” тоглолт 15/
 99. 2021.12.10. УБТ: Улаанбаатар театрын өвөл цагийн нээлт
 100. 2021.12.11. Туушин 5д: НИТХ Хүн нам 2/
 101. 2021.12.13. “Бөртэ чоно” шагнал гардуулах ёслолын ажиллагаа 10/

Ерөнхий сайд	2	Өөрийн байранд тоглосон тоглолт:	5
УИХ	1	Оролцсон уран бүтээлчид:	156
МАН	1	Үзэгчдийн тоо:	1230
Шадар сайд	9	Гадуур захиалгат ажил:	103
СЯ	1	Оролцсон уран бүтээлчид:	721
НИТХ	4	Үзэгчдийн тоо:	5.332.208
НЗДТГ, харьяа газрууд	32		
УБ театр	58		
Нийт ажлын тоо:			108
Нийт оролцсон уран бүтээлчдийн тоо /давхардсан тоогоор/:			877
Нийт үзэгчдийн тоо /давхардсан тоогоор /			5.333.438

2/ Хүний нөөцийн ил тод байдал

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг баримтлан ажилласан байдал:

8.1.1. Сул орон тооны зарыг цахим сүлжээ болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах гэсэн заалтын дагуу:

Тайлант хугацаанд бүрэн орон тоогоор ажиллаж байгаа төдийгүй цар тахлын хөл хорионы нөхцөл байдлын улмаас соёл урлагийн байгууллагын үйл ажиллагаа хумигдмал байгаа шалтгаанаар чуулгын хүний нөөцөд шилжилт хөдөлгөөн хийгдэх нөхцөл байдал үүсээгүй байгаа тул сул орон тооны мэдээлэл байгууллагын мэдээллийн аль ч сувгаар хийгдээгүй. Жирэмсний амралтаа авсан 2 уран бүтээлчийн оронд түр орон тоон дээр байгууллагын хүний нөөцөд бүртгэлтэй бүжигчин З.Энхжаргал, их хуур хөгжимчин А.Ууганбаяр нарыг авч ажиллуулсан.

8.1.2. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх гэсэн заалтын дагуу:

Улаанбаатар чуулгын даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан Улаанбаатар чуулгын ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрмийг www.ubchuulga.mn цахим хуудсанд байршуулсан, уран бүтээлийн анги тус бүрээр дүрэм журмын хавтас нээж албан хаагч нарт танилцуулсан. 2021 онд ёс зүйн зөрчил гаргаж, арга хэмжээ авагдсан албан хаагч байхгүй болно.

8.1.3. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх заалтын дагуу:

Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратегийн гол асуудал болох чадварлаг хүний нөөцийг сонгон авч, түүнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын бүтээмж, ур чадварыг бодитой үнэлэх, урамшуулах, сэтгэл ханамжийг өндөр байлгах тал дээр анхаарч ажилладаг. Нийслэлийн харьяа мэргэжлийн урлагийн байгууллагын хувьд нийслэлийн засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахын зэрэгцээ Монгол Улсын Төрийн албан тухай хууль, Соёлын тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан 62 хүний орон тоонд бариулан ажиллуулж байгаа 27 мэргэжлийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөл, Соёлын яамнаас гаргасан жишиг албан тушаалын тодорхойлолтыг мөрдлөг болгон шинэчилж чуулгын даргын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/05 дугаар тушаалаар баталж, нийт албан хаагчдад танилцуулан гарын үсэг зуруулж, албан хаагч тус бүрийн хувийн хэрэгт 1 хувийг, албан хаагчийн ажлын хавтсанд 1 хувийг хадгалуулав. Тус албан тушаалын тодорхойлолтод нийцсэн чадварлаг мэргэжлийн хүмүүсээр нөөцөө бүрдүүлэн, албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс, нэмэгдэл олговор, шагнал урамшуулал, тусламж дэмжлэгийг зохих журмын дагуу олгож, албан хаагчийн сургалтын хөтөлбөр, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан тухай тайлан, мэдээг театрын албан хаагчдын дотоод сүлжээн дэх цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан мэдээлж ажилласан.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг улирал бүр хийж захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн, ур чадварын нэмэгдэл хөлсийг олгож хэвшсэн. Цар тахлын улмаас байгууллага бүрэн хүчин чадлаар үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллах боломжгүй байгаагийн улмаас 2021 онд ажил мэргэжилдээ хариуцлагатай хандаж, амжилт гаргасан болон уран бүтээлийн тайлан тоглолтоо үзэгч олны хүртээл болгосон, улсын чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцсон албан хаагчдад шагналт цалин болгон ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг олгож ажилласан. Цар тахлын үеэр соёл урлагийн үйл ажиллагаа хориглож, эдийн засгийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан уран бүтээлчид сул зогсолтын хэлбэрээр цалинжиж ажиллаж байсан үеэр ур чадварын нэмэгдэл болон үр дүнгийн урамшуулалд бүрэн хэмжээгээр хамрагдаагүй зөвхөн хэвийн горимоор ажиллаж байсан захиргааны албан хаагчдад ур чадвар, урамшууллыг тооцон олгох хэлбэрээр ажил мэргэжлийн онцлогтой уялдуулан урамшууллыг тооцон ажилласан. Энэ тухай бүхий л шинэ мэдээ, мэдээллийг тухай бүр цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажилласан.

8.1.4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх заалтын дагуу:

2021 оны 1 дүгээр сараас эхлэн Улаанбаатар чуулгын шинэ www.ubchuulga.mn вебсайтыг ажиллагаанд оруулж, хүний нөөцийн ил тод байдлыг хангасан. Вебийн шинэ бүтцэд албан хаагчдын танилцуулга, албан тушаалын тодорхойлолтууд, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр түүний биелэлтүүд, сургалтын хөтөлбөр түүний хэрэгжилтийн тайлан, албан хаагчдын ур чадвар, ажлын ачааллыг үнэлж дүгнэсэн байдал, сул орон тооны тухай мэдээлэл, шинээр ажилд орсон албан хаагчдын талаарх мэдээлэл гэх мэтчилэн байгууллагын хүний нөөцийн удирдлагын талаарх бүхий л

мэдээллийг тайлагнаж, ил тод мэдээлэх нөхцөл бүрдүүлэн ажилласан. Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг мэдээллийн самбар болон социал сүлжээн дэх өөрийн хуудсан дээр байршуулан мэдээлж, тухай бүр шинэчилж ажилласан. Мөн байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмыг ubchuuлга.mn сайт болон дотоод үйл ажиллагаанд албан хаагчдад нээлттэй танилцуулах хавтсанд хийж хадгалж, түүний баяжилтыг тухай бүр хийж хэвшсэн.

8.1.6.Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлэх заалтын дагуу:

Хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн талаархи үнэн зөв мэдээллийг бэлтгэн, байгууллагын мэдээллийн самбар болон дотоод ажлын UB ENSEBMLE STAFF группээр дамжуулан албан хаагчдад цаг алдалгүй хүргэн ажиллаж байна.

Нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр: Бакалавр, магистрын чиглэлээр мэргэжлийн сургуульд элсэн суралцаж байгаа албан хаагчдад суралцах нөхцлийг хангаж, ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хийж, ажлын ачааллыг тэнцвэржүүлж ажилласан.

Дотоодын их дээд сургуулиудад суралцаж байгаа албан хаагчид:

Нэр	Сургууль	Мэргэжил	Зэрэг, дэв
Б.Баатархүү	Сити Их сургууль	Урлаг судлал	Магистр
А.Ууганбаяр	Монгол Улсын Консерватори	Их хуур хөгжимчин	Магистр
Г.Чимэд	Хүмүүнлэгийн Ухааны ИС	Англи хэлний орчуулагч	Бакалавр
Э.Дашням	Соёл урлагийн Их сургууль	Дуулах урлаг	Магистр
Б.Эрхэмбаяр	Монгол Улсын Консерватори	Удирдаач	Магистр
Ц.Энхмаа	Соёл урлагийн Их сургууль	Хөгжимчин-багш	Магистр
Т.Санжаажамц	Соёл урлагийн Их сургууль	Морин хуур хөгжимчин	Магистр
Д.Баярт	Соёл урлагийн Их сургууль	Бүжгийн багш	Магистр
Б.Бат-Өрнөх	Сити Их сургууль	Урлаг судлал	Магистр
Б.Сувд-Эрдэнэ	Тэнгэр дээд сургууль	Архив судлал	Бакалавр

Морин хуур хөгжимчин Н.Энхбат, маркетингийн менежер М.Энхтуул нар Монголын Урлагийн зөвлөлийн дэргэдэх Соёл урлагийн залуу манлайлагчийн 1 жилийн тэтгэлэгт хөтөлбөрт тус тус хамрагдан суралцаж байна.

Албан хаагчдын хамрагдсан сургалтууд:

- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигаас урьдчилан сэргийлэх тухай” анхан шатны сургалт 3/3
- “Хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх нь” сургалт 2/2
- Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн цахим системийг ашиглах нь 2/1
- Хүний нөөцийн нэгдсэн систем (ХННС)-ийн хэрэглэгчийг чадавхжуулах сургалт 1/1
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад зориулсан хуулийн сургалт 10/10
- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нь 3/3
- Аж ахуй нэгж байгууллагуудыг эрсдэлээс хамгаалах стандартын танилцуулах сургалт MNS ISO 22301:2020, MNS ISO 22320:2020, MNS ISO 22395:2020, MNS ISO 31000:2020 сургалт 5/5

- Архив албан хэрэг хөтлөлтийн edoc-системийн ашиглалтыг сайжруулах онлайн сургалт 3/3
- Монгол улсын засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол танилцуулах Архив, албан хэрэг хөтлөлтийн цахим сургалт 2/2
- MS EXCEL программыг ашиглах ур чадварыг сайжруулах анхан болон дунд шатны сургалт 8/8
- Монголын Урлагийн зөвлөлөөс зохион байгуулсан “Motion Mongolia” Модерн бүжгийн сургалт 11/11
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалт 62/48
- “Зөв хооллолт эрүүл амьдралын баталгаа” сургалт 62/39
- Үйлчилгээний албан хаагчдын ёс зүй, харилцааны ур чадвар цахим сургалт 62/51
- Ажлын байрны дасгал хөдөлгөөн” сургалт 62/42
- Албан хаагчдад зориулсан Монгол бичгийн танхимын сургалт – 7 хоногт 1 удаа.

Нийгмийн асуудал шийдвэрлэхээр хийсэн ажлууд:

Нэг удаагийн тусламж, дэмжлэг: Ар гэрт нь гачигдал гарсан 4 албан хаагчид байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгов.

№	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Шалтгаан	Мөнгөн дүн
1	О.Анхчимэг	Гоцлол дуучин	Төрсөн эцэг нас барсан	300,000
2	Ц.Батцэнгэл	Тонмейстр	Төрсөн дүү нас барсан	200,000
3	Г.Гантуяа	Ятга хөгжимчин	Төрсөн эцэг нас барсан	300,000
4	Б.Өнөрцэцэг	Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Эмчилгээний зардалд	300,000

Хүүхдийн баяраар чуулгын албан хаагчдын 90 хүүхдэд Хан бүргэдэй их дэлгүүрийн хүүхдийн бэлгээр албан хаагчдынхаа хүүхдүүдэд бэлэг барихаар гэрээ хийсэн. Тус үйл ажиллагаанд зориулагдсан 2,607,300 төгрөгийн зардлыг чуулгын даргын тушаалаар, зохих журмын дагуу байгууллагын төсвөөс гаргаж санхүүжүүлсэн.

Албан хаагчдын ажлын байрны нөхцлийг сайжруулахад:

- Албан хаагчдын ажлын ур чадвар, үр дүнг үнэлэн шагналд тодорхойлж шагнуулав.
- Нэг удаагийн тэтгэмжид 1.100.000 төгрөг
- Хөгжмийн тоног төхөөрөмжийн задас сэлбэг, засвар үйлчилгээнд 6.204.260 төгрөг
- Эд хогшил худалдан авах зардалд 3.420.560 төгрөг
- Бичиг хэргийн зардалд 1.338.096 төгрөгийн зардал гаргаж ажилласан.

3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Театрын захиргаанд хандаж, 2021 онд 12 дугаар сарын15-ныөдрийнбайдлаар чуулгын захиргаанд хандаж албан хаагчдаас 2, иргэнээс 2, нийт 4 өргөдөл бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийг 100 хувь хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Тус өргөдлүүд нь жирэмсний амралт авах тухай 1, хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа эргэн орох 1, иргэнээс ажилд орох тухай 2өргөдлийг хүлээн авч бүртгэсэн. Бүжигчин Ж.Номгонмаа жирэмсний амралтаа авах, Бүжигчин Э.Чаминчулуун хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орох хүсэлт ирүүлсэн бол иргэн А.Ууганбаяр, З.Энхжаргал нар ажилд орох тухай хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэж, өргөдлийн хариуг хүргүүлсэн.

- **Шагнал, бусад амжилтууд**

№	Нэр	Албантушаал	Шагналынтөрөл
Загийн газрын болон салбарын шагнал:			
1	С.Эрдэнэцэцэг	Нягтлан бодогч	Банк, санхүүгийн тэргүүний ажилтан
2	Р.Сийлэгмаа	Тайзны машинист	Соёлын тэргүүний ажилтан
3	Б.Доржпүрэв	Гэрэлтүүлэгч	Соёлын тэргүүний ажилтан
4	Г.Батсүх	Гэрлийн техникч	Соёлын тэргүүний ажилтан
5	Ч.Мэндсайхан	Бүжигчин	Соёлын Яамны “Жуух бичиг”
6	Э.Мөнх-Алдар	Бүжигчин	Соёлын Яамны “Жуух бичиг”
7	Б.Цэвэлсүрэн	Бүжигчин	Соёлын Яамны “Жуух бичиг”
8	Э.Балжинням	Бүжигчин	Соёлын Яамны “Жуух бичиг”
8	Б.Сувд-Эрдэнэ	Архивын эрхлэгч	Архивын Ерөнхий газрын “Жуух бичиг”
10	Б.Өнөрцэцэг	ДАТМБХ мэргэжилтэн	Архивын Ерөнхий газрын “Жуух бичиг”

Тайлант хугацаанд бүжгийн багш Д.Баярт, гоцлол бүжигчин Б.Норовбанзад нарын хамтарсан “RED” уран бүтээлийн тайлан тоглолт, Гоцлол хөгжимчин Б.Мягмарцэрэнгийн “Хан Хөхийн уянга” нэртэй бие даасан тоглолт, хөгжим ангийн уран бүтээлчдийн “Баярын үдэш” концертыг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж, байгууллагын зүгээс урын сангаа баяжуулсан, ур чадвараа нэмэгдүүлсэн, үзэгч олонд тайлангаа тавьсан, шинэлэг урсгал чиглэлийн бүтээл туурвисан албан хаагчдаа дэмжиж урамшуулсан. Мөн Оны шилдэг дуу шалгаруулах “МОРИН ХУУР” дууны наадамд амжилттай оролцож, III байр эзэлсэн гоцлол дуучин, МУГЖ С.Ганзориг, дуучин Ж.Буянтогтох нарыг дээрх уран бүтээлчдийн адил бүх талаар дэмжиж, байгууллагын зүгээс урамшуулсан. Дээрхи албан хаагчдын шагналын материалыг бүрдүүлэх, уралдаанд бэлдэх, оролцох боломжоор хангаж, ажлын цагийн зохицуулалтыг хийж ажилласан.

3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Улаанбаатар чуулга нь erp.ulaanbaatar.mn цахим программын Өргөдөл, гомдлын системийг ашиглан өргөдөл, гомдлыг бүртгэж хянан шийдвэрлэдэг. Байгууллагад хандаж албан хаагчдаас болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг театрын хүний нөөцийн менежер хүлээн авч, бүртгэж, шийдвэрлэх асуудлыг хариуцан ажилладаг.

Чуулгын захиргаанд хандаж, 2021 онд 12 дугаарсарын15-ныөдрийнбайдлаар чуулгын захиргаанд хандаж албан хаагчдаас 2, иргэнээс 2, нийт 4 өргөдөл бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийг 100 хувь хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. Тус өргөдлүүд нь жирэмсний амралт авах тухай 1, хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа эргэн орох 1, иргэнээс ажилд орох тухай 2 өргөдлийг хүлээн авч бүртгэсэн. Бүжигчин Ж.Номгонмаа жирэмсний амралтаа авах, Бүжигчин Э.Чаминчулуун хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орох хүсэлт ирүүлсэн бол иргэн А.Ууганбаяр, З.Энхжаргал нар ажилд орох тухай хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэж, өргөдлийн хариуг хүргүүлсэн. Тус чуулга нь мэргэжлийн урлагийн байгууллага бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан иргэдээс ажилд орох хүсэлт, албан хаагчдаас ажлаас түр болон бүр чөлөөлөгдөх хүсэлтүүд, бусад ажлын гүйцэтгэл, сахилга бат, нийгмийн байдлыг шийдвэрлүүлэх хүсэлтүүд ирснээр театрын дарга тухайн өргөдөлтэй танилцан шаардлагатай тохиолдолд театрын захиргааны зөвлөл болон уран сайхны зөвлөл хуралдан шийдвэрлэсэн.

3.6 Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагч нарын байгуулсан үр дүнгийн гэрээнд заагдсан ажлуудыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэж 70 хувийн биелэлттэй байгаа бөгөөд мэдээ тайланг НЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

1. Архивын ажлын зохион байгуулалт үйл ажиллагаа:

“Байгууллагын архивын үндсэн заавар” /БААҮЗ/ Баримт бичгийн стандарт MNS 51401:2011 MNS 5140-2:2011 MNS 5140-3:2011 “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” /ТАХХҮЗ/ “Тамга тэмдэг баталгааны тэмдэг хэрэглэх заавар” холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллаж Захиргааны албан бичиг боловсруулсан албан хаагчдаас ирсэн явуулсан харилцсан бичиг тэдгээрийн хавсралт бүхий баримт бичгүүдийн боловсруулалт стандартын хэрэгжилтийн байдал хяналт тавьж ажиллаа.

Нийслэлийн засаг даргын захирамжын 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/172 тоот журам буюу Байгууллагын архивын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага хадгалалтын горимыг тогтоож мөрдөх журмын дагуу ажиллаж байна.

Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам буюу 2015 оны 03 дугаар сарын 06- ны өдрийн А/177 дугаар тоот журмыг даган мөрдөж ажиллаж байна. Монгол улсын засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх журам” Нийслэлийн Засаг Даргын 2017 оны А/252 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” Нийслэлийн архивын газрын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 02/244 тоот “Захирамжийн хэрэгжилтийг хангуулах тухай” Нийслэлийн засаг даргын 2015 оны 07 сарын 29-ны өдрийн А/633 дугаар захирамж” зэргийг дагаж мөрдөн ажиллаж байна.

Архив, албан хөтлөлтийн хэрэгцээнд Нийслэлийн Архивын газрын “Архив, албан хэрэг хөтлөлтийн систем, тусгай төрлийн баримттай ажиллах арга зүй 2018” ном “Архив, албан хэрэг хөтлөлтийн талаархи эрх зүйн болон арга зүйн баримт бичгийн эмхэтгэл-2018” зэрэг номнуудыг авсан байна.

Байгууллагын архивын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулав.

2. Нөхөн бүрдүүлэлт, тоо бүртгэл

Байнга түр 70 жилийн баримтыг стандартын дагуу үдэж хавтаслаж бүртгэлжүүлсэн. Нийслэлийн Архивын газрын даргын 2019 оны А/64 дүгээр тушаалаар “Тусгай төрлийн баримтыг зохион бүрдүүлэх тоо бүртгэл, нөхөн бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагааны заавар”-ын дагуу байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүссэн гэрэл зураг, дүрс бичлэг, цахим баримт, гэрэл зургийн цомог зэргээр нөхөн бүрдүүлэлт хийж ажиллав.

Цахим баримт (скайнердсан) /даргын А тушаал 01-24/ Б тушаал 01-54/, Ирсэн бичиг 395, явсан бичиг 199, Үр дүнгийн гэрээ, биелэлт, Дээд газраас ирсэн Захирамж, хурлын тэмдэглэл, тайлан төлөвлөгөө зэргийг хуваарийн дагуу файлаар дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Б.Өнөрцэцэгээс хүлээн авав.

Нийслэлийн дотоод удирдлагын “UB ERP” нэгдсэн системийн <https://arch.ulaanbaatar.mn/> системд шивж нөхөн бүрдүүлэлтээ хийв.

Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндсэний хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын

баримтанд цахим хувь үйлдэх тухай” А/452 дугаар захирамжын дагуу 2006-2029 оны захирамжлалын 508, хуудасны тоо 43497, баримтын тоо 1563 баримт хавсаргасан цахим хувь болон хавсралтуудын бүрдэл, үг үсгийн алдаанд нягтлан шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж нөхөж хийж 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын баримт А тушаал 01-23 тоот 68 хуудас баримт Б тушаал /01-37/ тоот 88 хуудас баримтыг цахимаар хүлээн баримтаар авч “UB ERP” нэгдсэн системийн “Archive edoc”-д <https://arch.ulaanbaatar.mn/> нөхөн бүрдүүлэлт хийв.

Байгууллагын архивт тавигдах шаардлагын дагуу байгууллагын боломжид тулгуурлан шаардлагатай тоног төхөөрөмж болон аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Архивын тухай хуулийн 23.1.9 дэхь заалтын дагуу Төрийн архивт баримт шилжүүлэх хугацаа болсон тул 2019 оны 04 сарын 22-ны өдөр Нийслэлийн Архивын газарт төлөвлөгөөт нөхөн бүрдүүлэлтээр 2011-2014 оны байнга хадгалах 131 хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгч актаа хүлээн авлаа. Мөн 2020 оны үйл ажиллагаагаар байгууллагын түүхчилсэн лавлах үйлдэж баяжилт хийлээ.

Архив албан хэрэгт тогтмол ашиглаж байгаа компьютер, түүний үйлдлийн системийн найдвартай байдал, аюулгүй ажиллагааг хангахын тулд лицензтэй үйлдлийн систем болон вирусын програмыг ашиглаж байна.

3. Эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын үйл ажиллагаа:

Архивт хүлээн авсан баримтыг батлагдсан бүртгэл, тоо ширхэг, стандартын дагуу зөв байрлуулан байнга, түр 70 жил тусгай төрлөөр төрөлжүүлэн байрлал заагч хийж байрлууллаа.

Архив албан хэрэг хөтлөлтийн сургалт арга зүй.

2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Монгол улсын засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол танилцуулах Архив, албан хэрэг хөтлөлтийн цахим сургалтанд хамрагдсан.

2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр НЗДТГ-аас зохион байгуулсан Хяналт-Шинжилгээ үнэлгээний сургалтанд хамрагдан шалгалт өгч 60% дүн авсан.

4. Хадгалалт хамгаалалт

Архивын зориулалтын өрөө тасалгаанд зориулалтын нягтруулсан шүүгээнд сэдэв зүйн заалтын дагуу архивын баримтыг байнга, түр, 70 жилийн дарааллаар нь ангилан өрж байрлуулсан. Мөн тусгай төрлийн баримт болох гэрэл зураг дүрс бичлэг гэрэл зургийн цомог зэргийг нягтруулсан шүүгээнд байрлуулсан хадгалж байна.

Хадгаламжийн сангийн өрөөны тавиур шүүгээ хавтасны тоос шороог 7 хоногт 2 удаа тоос соруулж, өрөөний шал цонхны тавцан тавиур зэргийг халдваргүйжүүлэх бодисын уусмал чийгтэй цэвэрлэгээг үйлчилгээний ажилтангаар /2%/ийн формалин/-аар жилд 2-оос доошгүй удаа ариутгах ажлын үйлчилгээний ажилтнаар тогтмол хийлгэж байна.

Хадгаламжийн сангийн өрөө чийг дулаанын эрс хэлбэлзэлтэй байдаг. Агааржуулалтын системгүй болохоор агаар чийгшүүлэх, хуурайшуулах техник хэрэгсэл ашиглах, халаалт тохируулах, агаар оруулах зэрэг ажлыг өөрийн биеэр биечлэн өдөр тутам арга хэмжээг авч ажилладаг. Агаарын чийгшил 70-80 % хүртэл удаан хугацаагаар хадгалагдах тохиолдолд дээрхи нөхцлийг хэвийн болгох зорилгоор эрчимтэй агааржуулах, салхи оруулах, хуурайшуулах, чийгшил ихдэж буй арга шалтгааныг тогтоож арилгах арга хэмжээг авч ажиллав.

Чийг дулааны хэмжээг тогтмол хянаж бүртгэл хөтөлдөг.

Архивын өрөөг хөгц, хорхой шавьж, хортон мэрэгчээс хамгаалж хор цацуулж байнгын цэвэр нөхцөлд байлгадаг. Архивын өрөөнд 2021 оны 05 сарын 24-ны өдөр хортон шавьж устгах газраас шавьж устгах хор цацуулав.

Архивын өрөөний зохион байгуулалт, цэвэрлэгээ үйлчилгээг өдөр тутам хийж байна.



Албан хэрэг хөтлөлт, ирсэн, явсан бичгийн шийдвэрлэлтийн байдал:

Тус газар нь албан хэрэг хөтлөлтийн баримт бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтөлж байна. Албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг боловсруулалт, бүртгэл, шилжүүлэг, шийдвэрлэлт, архивлалт, хяналт, тайлагналт, хэвлэмэл хуудасны захиалга, лавлах бүртгэлийн үйл ажиллагааг www.edoc.ub.gov.mn онлайн албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр хөтлөн явуулж байна. Баримт бичигт шийдвэрлэх хугацааг заасан, дурдсан хугацаанд нь шийдвэрлэж, шийдвэрлэх шатандаа буй бичгийг хариуцсан албан хаагч нь ажлын өдрүүдэд шийдвэрлэлтийн талаар явцын тэмдэглэл хөтөлж байна.

2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Монгол улсын засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол танилцуулах Архив, албан хэрэг хөтлөлтийн цахим сургалтанд хамрагдан нийтлэг журмын дагуу ажиллаж байна.

➤ Байгууллагад ирсэн нийт бичиг	200
➤ Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо	2
➤ Системээр бүртгэгдсэн бичгийн тоо	57
➤ Хуваарилагдсан бичгийн тоо	60
➤ Хариутай бичгийн тоо	
➤ Хугацаандаа шийдвэрлэгдсэн	155
➤ Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь	99%
➤ Хариугүй бичгийн тоо	55
➤ Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	2
➤ Судалж байгаа	5
➤ Явуулсан бичиг 115, хариутай 13, хариугүй 102 , цахим edoc системд 100	

хувь бүртгэсэн, программ ашигладаг байгууллагуудад илгээж ажилласан. Байгууллагын албан бичгийг шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, ирсэн бичгийг шилжүүлэх, баримт бичиг боловсруулах, баримт бичгийн эргэлт хэвийн явагдаж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

“Нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д тухайн жилд гаргах тайлан, мэдээний тухай мэдээлэл;

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 100 дугаар тогтоолын 7-р хавсралтын дагуу “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар гарган, биелэлтийг НЗДТГ-ын ХШҮХ, НСУГ, цахим хэлбэрээр оруулсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ”

4.1 Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал

Нийслэл дэлгэц ХХК-ийн том дэлгэцээр бүжиг дэглээч, бүжгийн багш Д.Баярт, гоцлол бүжигчин Б.Норовбанзад нарын “Red” бүжгийн тоглолтын мэдээлэл, сурталчилгаа нэвтрүүлсэн.



C1 телевиз, Youtube Sanjaa show channel-аар Хийлч Ч.Дэлгэрцэцэг Улаанбаатар чуулга 15 жилийн ойн дээрээ Театр болсон тухай энтертайнмент нэвтрүүлэгт цацсан.

- Late night of Miko шоуны шинэ жилийн тусгай хөтөлбөрт Хийлч МУСТА Ч.Дэлгэрцэцэг, Э.Дашням нар театрын тухай болон уран бүтээлийн дээжээсээ толилуулав.
- Юнилайв 88, ДДИШ 900, Look ТВ IPTV-үүдээр бүжиг ангийн 10 жилийн ойд зориулсан “10 жил” бүжгийн тоглолтыг шууд дамжуулав.
- UBS ТВ-ийн “Өглөөний хөтөлбөр”-ийн “Ажилсаг Улаанбаатар” буланд Улаанбаатар театрын уран бүтээлийн тухай 2 удаагийн нэвтрүүлэгт оролцов.
- Монгол HD тв-ийн өглөө хөтөлбөрт уран бүтээлчид
- МҮОНРТВ-ийн “Урлаг” нэвтрүүлгийн Соёлын цаг буланд “Red” тоглолтын мэдээлэл, “Colors of Mongolia” тоглолтын талаар нэвтрүүлсэн.



Аmагaа's weekly шоунд
Улаанбаатар театрын дарга
Р.Мөнхсайхан зочноор
уригдлаа.

- Үндэсний мэдээллийн Монцамэ агентлагийн сэтгүүлд онцлох уран бүтээлчдийн тухай мэдээлэл А4 нийтлэл,
- Монцамэ сэтгүүлд Улаанбаатар театрын дарга Р.Мөнхсайханы театрын үйл ажиллагаа, их хотын театрын тухай ярилцлага
- Стар ТВ-ээр “Хан хөхий уянга” Лимбэ хөгжимчин Б.Мягмарцэрэнгийн соло тоглолт
- Ёочин хөгжимчин Ч.Марал-одтой Улаанбаатар театрын поп оркестрын хамтарсан “Vivace” тоглолтын бичлэгийг нэвтрүүлсэн.
- Юнивиш, ДДИШ, Look TV-д “Мауглитай танилцсан нь” циркчилсэн үзүүлбэрийг контент болгон байршуулав.
- Бүжгийн “10 жил” бүжиг ангийн 10 жилийн ойд зориулсан тоглолтын бичлэгийн 12 дугаар сарын 31-ний өдөр Стар ТВ-ээр нэвтрүүлнэ.

4.2 Төсөв, санхүүгийн ил тод байдал

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай;

Шилэн дансны тухай хуулийн дагуу Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэн сар бүр байгууллагын төсвийн гүйцэтгэл, улирал бүр санхүүгийн тайланг гаргаж мэдээллийг тогтмол шинэчилж архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтэрч татан авч хэвлэх боломжтой. НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн баталгаажуулан байгууллагын цахим хуудсанд Төсөв, санхүүгийн ил тод байдал Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2021 оны жилийн төсөв, сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, төсөв хөрөнгөтэй холбоотой тушаал шийвдэр, таван сая төгрөгнөөс дээш гүйлгээний орлого, зарлагын мэдээлэл болон бусад холбогдох баримт мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон шилэн дансанд байршуулж иргэд олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн.



4.3 Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын зохион байгуулалт:

2021 ОНЫ ДОТООД ХЯНАЛТЫН АЖЛЫН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ 100%.

- Ажлын байрны эрсдлийн үнэлгээг матрицын аргаар хийж дүгнэлт нь 9 буюу эрсдэл хамгийн бага гэж гарсан.
- Корона вирусын цар тахлын нөхцөлд учирч болох эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлоход авч хэрэгжүүлэх алхмуудыг боловсруулж батлуулсан.
- Орж ирсэн албан хаагч, үзэгчдийгавтомат ариутгагчаар ариутгаж, халууныг хэмжиж, QR бүртгэлийг киоск дэлгэцэнд, байршуулж, QR кодыг тогтмол уншуулах шаардлага тавин ажиллаж байна. Мөн үйлчлүүлсэн иргэд, албан хаагчдад маскаа зүүж, гараа

ариутгах шаардлага тавихыг хамгаалалтын албанд зөвлөмж болгов. Гар ариутгалын автомат төхөөрөмжийн бодисыг сэлбэж, төхөөрөмжийн цэвэрлэгээг хийж байгаа эсэхэд байнгын хяналттай байна.

- Тоглолт үзэхээр ирсэн үзэгчдийн халуун хэмжиж, вакцины III тун хийлгэсэн эсэхэд вакцины гэрчилгээг шалган нэвтрүүлсэн.
- Мэдээллийн самбар болон хаалга тус бүрт цаг үеийн шинж чанартай мэдээ мэдээллийг тогтмол байршуулахаас гадна чуулгын байран дотор /оффис, их танхим, коридор г.м/ зай барих тэмдэг тэмдэглэгээг нааж байршуулав.
- Мөн үзвэрийн танхим дахь суудал хооронд зай барих тэмдэглэгээ байршуулж үзэгчдийг халдвар хамгааллын дэглэмээ мөрдөхийг тогтмол сануулж байна.



ХЭРЭГЛЭГЧИЙН СУДАЛГАА

2021 оны 12 дугаар сарын 10-ны **“Colors of Mongolia”** өвөл цагийн нээлтийн тоглолтын үеэр авсан **“Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа”**-ны асуулга, дүгнэлт.

1. Таны нас:

- А. 16-25
- Б. 26-25
- В. 36-45
- Г. 46-55
- Д. 55-аас дээш

2. Танд манай чуулгын байранд үзвэр үзэхэд орчин нь сэтгэлд нийцэж байна уу? Үгүй бол яагаад гэдэгээ бичнэ үү.

.....
.....

3. Үзвэр үйлчилгээнээс хамгийн чухалд тооцдог 3 хүчин зүйлээ дугуйлна уу.

- А. Орчин
- Б. Тав тухтай суудал
- В. Тоглолтын чанар
- Г. Уран бүтээлчид
- Д. Бусад

4. Өнөөдрийн үзсэн Color's of Mongolia тоглолтод өгөх таны үнэлгээ хэд вэ?

- А. Маш сайн
- Б. Сайн
- В. Дунд
- Г. Муу
- Д. Маш муу

5. Улаанбаатар театрын тоглолтын талаар санал хүсэлт, цаашид сайжруулах шаардлагатай гэж үзсэн зүйлсээ бичнэ үү.

Дүгнэлт: Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг нийт 100 хүнээс авахад 25-75 насны үзэгчид байсан бөгөөд 60 орчим хувь нь үзвэр үйлчилгээнээс тав тухтай орчин хамгийн чухал гэсэн бол 24 хувь нь тоглолтын чанар, үлдсэн 16 хувь нь уран бүтээлчид чухал гэж үзсэн байв.

“Танд манай чуулгын байранд үзвэр үзэхэд орчин нь сэтгэлд нийцэж байна уу? Үгүй бол яагаад гэдэгээ бичнэ үү” гэсэн асуултад 67 хүн тийм гэж дугуйлсан бол үлдсэн 33 хүнээс суудал тухгүй, заал хүйтэн, үзэгчид маш их орж гарч хаалга онгойлгож байсан тул тухай үзэж чадаагүй гэсэн хариултаудыг өгсөн байв.

Өнөөдрийн үзсэн Color’s of Mongolia тоглолтод өгөх таны үнэлгээ хэд вэ? Гэсэн асуултад 85 хүн маш сайн гэж хариулсан бол 3 хүн сайн, 12 хүн дунд гэж хариулсан байв.

“Улаанбаатар театрын тоглолтын талаар санал хүсэлтээ бичнэ үү” гэсэн асуулгад хөтлөгчгүй тоглолтоо араас нь зарлаад явах нь дээр санагдсан гэсэн санал ирсэн байна.

Тоглолтын чанар сайн байгаа боловч цаашид уран бүтээлчдээ илүү чадавхжуулж, хөрвөх боломж нөхцлөөр хангаж ажиллах хэрэгтэй гэдэг нь асуулгын хариултаас харагдаж байна.

Хамгийн чухал нь орчин гэж дийлэнх үзэгч хэлсэн бөгөөд суудал тухгүй, заал хүйтэн байна гэсэн тул 2022 онд их танхимын суудлыг солих хэрэгцээ шаардлага гарч байна.

ТАВДУГААР БҮЛЭГ: “БУСАД МЭДЭЭЛЭЛ”

2021 оны 03 дугаар 30-ний өдөр Соёлын сайд Ч.Номингоор ахлуулсан шуурхай ажлын хэсэг Нийслэлийн Улаанбаатар чуулгад ажиллаж, халдвар, хамгааллын дэглэмийг хэрхэн сахиулж байгаа болон түр журмыг мөрдөхөд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлүүдтэй газар дээр нь биечлэн танилцлаа. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд МХЕГ, ОБЕГ зэрэг албаны бусад хүмүүс оролцлоо.





“ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ” БАЙГУУЛСАН НЬ

2021 оны 01 дүгээр тогтоолын 17-д заасны дагуу, “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.8 дахь заалтын дагуу Улаанбаатар чуулгын “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл”-ийг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдөр байгууллаа.

Эрхэм зорилго нь:


Улаанбаатар театрын залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, эрхийг хангах, байгууллага хоорондын хамтын ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадвар, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд энэхүү зөвлөлийн зорилго оршино.

Алсын хараа нь:

Нийслэлийн Улаанбаатар театрын үндсэн зорилго болох ардын урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний урлагийг орчин цагийн урлагтай хослуулан шинэ уран бүтээл туурвихад тулгамдаж буй асуудлуудад тус театрын залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.

Эрх, үүрэг нь:

- “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийн гишүүд нь шинэ санаачлага гаргах, тэдгээрийн үр дүнг шаардах эрхтэй;
- “Залуучуудын хөгжлийн зөвлөл” аливаа уулзалт семинар, хурал зөвлөгөөнийг зохион байгуулах эрхтэй;
- Залуучуудын санаачлага, сайн дурын үйл ажиллагааг дэмжих үүрэгтэй;
- ЗХЗ-ийн үйл ажиллагаа нь хүний эрх, хууль ёсыг дээдлэнэ
- ЗХЗ нь бусдыг сонсож ялгаварлан гадуурхахгүй байна
- Үйл ажиллагаа ил тод нээлттэй байна
- ЗХЗ-ийн гишүүд тэгш эрхтэй байна
- Эерэг хандлагатай байна
- Шинийг санаачлагч байна
- Идэвхитэй хамтрагч оролцогч байна
- Хариуцлагатай шударга, эх оронч үзэлтэй байна
- Өрсөлдөх чадвараа хөгжүүлнэ



2021 оны 06 дугаар сарын 02-ний өдөр Соёлын ямаас зохион байгуулсан “Залуучуудын хөгжлийн зөвлөл” анхдугаар хуралд бүжиг ангийн хамт олон оролцож мэндчилгээ дэвшүүлсэн.



БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДАЛ ЗАРЛАСНААС ХОЙШ УЛААНБААТАР ТЕАТРЫН БАЙРАНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Театрын дарга Р.Мөнхсайхан, ерөнхий найруулагч П.Урнаа, хүний нөөцийн менежер Л.Одгэрэл, Орон тооны гамшгаас хамгаалах штабын дарга Б.Түмэндэлгэр нар утсаар холбогдож нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцож, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, зохион байгуулалтын ажлуудыг хэрхэн зохицуулах талаар санал солилцож дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан.

- a. Улсын Онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрүүд, Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын захирамжийн талаар байгууллагын цахим сүлжээгээр албан хаагчдад танилцуулж мэдээлсэн.
- b. Дээрх тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж театрын даргын тушаал гарган, байгууллагын дотоод үйл ажиллагааны ажлын хуваарилалтын төлөвлөгөө гаргаж ажилласан.
- c. Театрын үүд болон угтах үйлчилгээний хэсэгт IP камер байрлуулан түүнийг 24 цагийн хяналттай байлгах. Хяналтыг Б.Түмэндэлгэр хариуцан ажиллаж байна.




2. Театрын дарга Р.Мөнхсайхан, дууны техникч Т.Цолмон, гамшгаас хамгаалах штабын дарга Б.Түмэндэлгэр нар Нийслэлийн засаг захиргааны 5-р байранд Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штаб байрласантай холбоотойгоор өдөр бүр 08.00-20.00 цагийн хооронд театрын байранд хяналт, зохицуулалтын үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

3. Байрны ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хуваарийн дагуу өглөө, өдөр, орой нийт 3 удаа тогтмол хийж хэвшсэн.



4. Захиргааны албан хаагчид ер системийн цахим бүртгэлээр захиргааны албан хаагчид гэрээсээ ажиллан ирцээ бүртгүүлж ажиллаж хэвшсэн.



5. Байгууллагын угтах үйлчилгээний хэсэгт тус байгууллагаар үйлчлүүлэх иргэдийн цахим бүртгэлийн QR кодыг хэвлэж байршуулсан.

6. Уран бүтээлчид болон тайз, техникийн ажилчдыг дуудлагын горимоор ажиллуулж, чуулгын байранд ирэхгүй, шаардлагагүй тохиолдолд гэрээсээ гарахгүй байх зааварчилгааг өгч ажилласан.

7. Захиргааны албан хаагчид зайлшгүй оффист ирэх тохиолдолд маскаа зүүх, гараа ариутгах, хүн хоорондын зайг барьж ажиллах санамж бүхий зурагт хуудсыг зохих газруудад байршуулсан.


Улсын Онцгой комиссын 861 дүгээр албан тоот, Улсын Онцгой комиссын 2 сарын 22-ны өдрийн 18 дугаарын тушаалаар баталсан “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр албан хаагчдын ажил үүргийн зохицуулалтыг хийж, байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулан ажилласан.

Театрын байранд зай барих тэмдэглэгээ байршуулж, их танхимд суудал хооронд зай барьж алгасаж суух хэвлэмэл хуудсыг нааж, мэдээллийн самбарт корона вирусээс сэргийлэх зурагт хуудас болон НОК, НЗД-аас ирүүлсэн түр журмыг өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн гаргаж байршуулсан. Мөн орох гарах хөдөлгөөнд хяналт хийж чуулгын уран бүтээлчид болон албан хаагчдыг зайлшгүй хотоос гарах хөдөлгөөн хийх тохиолдолд байгууллагын удирдлагад мэдэгдэж PCR шинжилгээ өгөх зааварчилгаа өгсөн. Захиргааны албан хаагчдыг ажиллах хуваарь гарган батлуулж хуваарийн дагуу халдвар хамгааллын дэглэмээ барьж ажиллах үүрэг даалгаварыг өгч өдөр тутмын үйл ажиллагааг доголдолгүй явуулж ажилласан.


Улаанбаатар театрын байранд 2021 оны 11 дүгээр сарын 15-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хүртэл 6 хоногийн хугацаатай Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт болж байгаа ба нийт 8000 гаруй албан хаагч орж, гарч үйлчлүүлсэн. Тэдгээр албан хаагч, болон шаардлагатай тохиолдолд орч, гарч буй иргэдэд амны хаалтыг тогтмол зүүх, гар барин мэндлэхгүй байх, гараа тогтмол угаах, гар ариутгагч хэрэглэх дадал хэвшлийг шаардлагыг тавин ажиллаж байна.

Улаанбаатар театрын нийт албан хаагчид КОВИД 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан байдал 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар: Нийт ажилтны тоо: 62. 1-р тунд хамрагдсан 61 /хувь 98.4%/, 2-р тунд

хамрагдсан 61 /хувь 98.4%/, 3-р тунд хамрагдсан 19 /хувь 30.7%/, цаашид нэмэлт тунд хамруулах ажлыг эрчимжүүлэх ажлуудыг зохион байгуулж ажиллаж байна.



"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" Нийт албан хаагчид өөрсдийн эзэмшлийн газарт мод тарих, нөхөн тарилт, цэнэг усалгаа, арчилгаа хийв.



Сайжруулсан түлшний нөөц, борлуулалт түгээлтийн талаар хийсэн ажил

2021 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн А/779 дүгээр захирамжийн дагуу сайжруулсан түлшний үйлдвэрийн үйл ажиллагааг сайжруулах, борлуулалтын цэгийн түлшний нөөцийг бүрдүүлэх, цэгийн тоог нэмэгдүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, түлшний хэрэглээг жигдрүүлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, түлшний хэрэглээг жигд хүртээмжээр хангах ажлыг зохион байгуулж БЗД-ийн 24-р хороонд албан хаагч нар ажилласан.

Нийслэлийн Онцгой Комиссын даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 15-р тушаалаар сайжруулсан түлш болон дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх хүрээнд БЗД-ийн 24-р хороонд даваа, лхагва, баасан гарагуудад ажиллаа.

ИЗД-ын А/779 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах Биестүүх дүүргийн 24-р хороонд ажиллах хувиар

№	Огноо нэр	Албан тушаал	Ажиллах үе	Утасны дугаар
1	Г.Манда	Даргаар	2021.10.26	80004266
2	О.Чамбат	Хөгжлийн зохиогч	2021.10.26	99062223
3	Ж.Бурматсүх	Дуучин	2021.10.26	99097948
4	Н.Билэвдорж	Дуучин	2021.10.26	99111147
5	Ц.Гансүх	Дуучин	2021.10.26	99925272
6	Б.Дэвснэ	Дуучин	2021.10.26	94121219
7	Б.Нарандэлгэр	Дуучин	2021.10.27	88118871
8	С.Аюулзориг	Концертмейстер	2021.10.27	99791959
9	Н.Араабатсүх	Морин хуур хөгжимчин	2021.10.27	89990128
10	А.Жамьянтүвшин	Завр бүрээ хөгжимчин	2021.10.27	80966077
11	Г.Дорноо	Дуучин төхөөрч	2021.10.27	99022581
12	Г.Бат - Огдой	Ин хуур хөгжимчин	2021.10.27	89391993
13	Б.Бат - Орших	Морин хуур хөгжимчин	2021.10.28	89021711
14	Н.Батсүх	Цэцэрлэг хөгжимчин	2021.10.28	99220583
15	М.Болдбаатар	Хөгжимчин	2021.10.28	89821832
16	А.Мөнхэн	Морин хуур хөгжимчин	2021.10.28	80090989
17	Б.Мендсүрэн	Ламбы хөгжимчин	2021.10.28	89049144
18	Т.Салсжавсүх	Морин хуур хөгжимчин	2021.10.28	95813591
19	А.Ууганбаатар	Ин хуур хөгжимчин	2021.10.29	88441031
20	Г.Зинбат	Морин хуур хөгжимчин	2021.10.29	89103923
21	Б.Эрхэмбаяр	Ундархан	2021.10.29	89034899
22	Д.Балдас	Бүтэгийн бэлч	2021.10.29	89017928
23	Ц.Мөнх-Алзар	Бүтэгийн	2021.10.29	89077817
24	Б.Цамцсүрэн	Благчин	2021.10.29	99915405
25	Ч.Мэндсүрэн	Дуучин	2021.10.30	99122623
26	Б.Энхсүрэн	Бүтэгийн	2021.10.30	89801484
27	Г.Батсүх	Гарийн төхөөрч	2021.10.30	89032030
28	Б.Доржсүрэн	Гардианууч	2021.10.30	89043986
29	Ц.Балдаспил	Томьёонч	2021.10.30	99980148
30	Б.Оюунзориг	Гардианууч	2021.10.30	99087790

Хувиар гаргасан: Хувий нэмэгдлийн менежер *[Signature]* И.Одгояр *(8009666)*



Тогтохгүй урсах цусаа харж айж балмагдсан “ЦУСНЫ ЭМГЭГ-тэй бяцхан хүүхдэд Хагалгааны ширээн дээр АМЬДРАЛ-ҮХЛИЙН заагт байгаа өвчтөнд ТӨРӨХИЙН ХҮНДРЭЛ-ээс амь нас дээсэн дөрөөн дээр байгаа эхчүүдэд Хэлж ирдэггүй хийсэж ирдэг осол гэмтэлд өртсөн хэн нэгэнд туслах Цусаа бэлэглэж, цохилох зүрх бүхнийг аваръя аяны хүрээнд Улаанбаатар театр нэгдэж цусаа хандивлалаа.



ХЯНАСАН:

ДАРГА

Р.МӨНХСАЙХАН

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН *Б.Өнөрцэцэг* Б.ӨНӨРЦЭЦЭГ

